

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
12 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 - 56
1. <i>Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	12 - 40
2. <i>“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	40 - 41
3. <i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	41 - 55
4. <i>Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.</i>	55 - 56

## Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 06-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 80 гишүүн хүрэлцэн ирж, 63.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, Т.Доржханд, Г.Лувсанжамц, Ч.Номин, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Ж.Галбадрах, Ч.Ундрэм;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан, П.Батчимэг, Ж.Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, С.Лүндэг, Б.Чойжилсүрэн;

Тасалсан: М.Бадамсүрэн, Х.Баттулга, Э.Одбаяр;

Хоцорсон: О.Амгаланбаатар – 04 минут, Т.Аубакир – 34 минут, Ц.Баатархүү – 08 минут, Э.Батшугар – 07 минут, Х.Булгантуяа – 13 минут, Л.Гантөмөр – 1 цаг 04 минут, Б.Жавхлан – 1 цаг 19 минут, Б.Жаргалан – 09 минут, Д.Жаргалсайхан – 08 минут, Б.Заяабал – 1 цаг 11 минут, Ц.Мөнхбат – 15 минут, Н.Наранбаатар – 1 цаг 34 минут, Б.Пунсалмаа – 25 минут, Ц.Туваан – 08 минут, Б.Тулга – 09 минут, А.Ундраа – 13 минут, Н.Учрал – 21 минут, Ж.Энхбаяр – 1 цаг 21 минут, С.Эрдэнэбат – 17 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хуралдааны эхэнд 12 дугаар сарын 06-ны буюу энэ өдөр ардчиллын төлөөх улс төрийн намууд нэгдэж, Монголын Ардчилсан намыг байгуулж, Монгол Улсын парламентын засаглалыг бэхжүүлэх, төгөлдөржүүлэх чиглэлд идэвхтэй улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаа зэргийг онцолж, парламентын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс Улсын Их Хурал дахь Ардчилсан намын гишүүд, ардчиллыг дэмжигч нийт иргэддээ баярын мэнд хүргэв.

**Нэг.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн

байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Д.Энхтүвшин, Ч.Анар, Ж.Алдаржавхлан, С.Амарсайхан, Б.Батбаатар, Ж.Баярмаа, А.Ундраа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Ж.Алдаржавхлан, С.Амарсайхан, Б.Батбаатар, Б.Жаргалан нар үг хэлэв.

*Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй санал томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, О.Цогтгэрэл, Э.Одбаяр, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “авч хэрэгжүүлэн, уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, А.Ариунзаяа, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 35

Бүгд: 100

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Х.Болормаа, Г.Очирбат, Б.Хэрлэн, М.Энхцэцэг, Д.Үүрийнтуяа, Р.Батболд, Г.Ганбаатар, Д.Батбаяр, Ж.Баярмаа, З.Мэндсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61  
Татгалзсан: 39  
Бүгд: 100  
61.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Амарбаясгалан:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 24  
Бүгд: 100  
76.0 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа.

*Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Ж.Ганбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 28

Бүгд: 103

72.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 32

Бүгд: 103

68.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**3.** Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 28

Бүгд: 103

72.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**4.** Байнгын хорооны саналаар Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 27

Бүгд: 103

73.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**5.** Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 27

Бүгд: 103

73.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 74.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**6.** Байнгын хорооны саналаар Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 64

Бүгд: 103

37.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

**7.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 49

Бүгд: 103

52.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**8.Байнгын хорооны саналаар Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 62

Бүгд: 103

39.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

**9.Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.**

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 56

Бүгд: 103

45.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 41

Бүгд: 103

60.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 45

Бүгд: 103



56.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**10.**Байнгын хорооны саналаар Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48  
Татгалзсан: 55  
Бүгд: 103

46.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

**11.**Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 31  
Бүгд: 103

69.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**12.**Байнгын хорооны саналаар “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 30  
Бүгд: 103

70.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**13.**Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80  
Татгалзсан: 23  
Бүгд: 103

77.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**14.**Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75  
Татгалзсан: 28  
Бүгд: 103

72.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15. Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 77

Татгалзсан: 26

Бүгд: 103

74.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсон тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороодод шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсох.***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц соёрхон батлах тухай, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулиудын эцсийн найруулгатай танилцлаа.

*Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 103 гишүүн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 06 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим  
10 цаг 12 минут

### ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

80 гишүүн ирцэд бүртгэгдэж, ирц 63.5 хувь болсон байна.

2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Одоогоос 24 жилийн өмнө 12 дугаар сарын 06-ны өдөр ардчиллын төлөөх улс төрийн намууд нэгдэж, Монголын Ардчилсан намыг байгуулж байсан түүхэн өдөр.

Ардчилсан намын тухайд ардчилал, өөрчлөлт, шилжилтэд шилжсэн тэр цаг үеэс хойш Монгол Улсын парламентын засаглалыг бэхжүүлэх, төгөлдөржүүлэх чиглэлд идэвхтэй үйл хэргээ оролцуулсан, идэвхтэй улс төрийнхөө үйл ажиллагааг явуулсан, төрийн эрхийг дангаараа болон хамтарч барилцаж явсан ийм түүхэн нам.

Тийм учраас парламентын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс Ардчилсан намын парламентын гишүүд болон энгийн гишүүд, ардчиллыг дэмжигч нийт иргэддээ энэ өдрийн баярын мэндийг хүргэж мэндчилж байна. /алга ташив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Нэг.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг  
дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл  
/Засгийн газар 2024.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
анхны хэлэлцүүлэг/**

---

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Индэрт урьж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо өнөөдөр өглөө 8 цаг 30 минутаас хуралдсан. Төсвийн байнгын хороо 09.00 цагаас хуралдсан.

Байнгын хороодын санал, дүгнэлтүүд боловсруулагдаж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэгт Ням-Осорын Учрал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Баярсайханы Солонгоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга. Мөн зарим улс төрийн намын дарга, удирдлагууд гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүн бүрдэж байгаа.

Байнгын хорооны санал, дүгнэлт ирж байна уу? Улсын Их Хурлын гишүүдэд цаг ашиглаад түр мэдээлэл өгье гэж бодож байна.

Өнөөдөр төсвийн ажлын хэсэг нийт 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдана. Улс төрийн намуудаас Улсын Их Хурлын гишүүдээс ирсэн санал хүсэлтийг үндэслээд 25 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж байгаа.

Ажлын хэсэг өнөөдөр үдээс хойшоос эхлээд ажлын хэсгийн хурлаа зохион байгуулж эхэлнэ.

Амралтын өдрүүдийг дамнаж хуралдаад нэг дэх өдөр үндсэндээ ажлын хэсэг эхний санал, дүгнэлтээ боловсруулна.

Ирэх Даваа гарагт бүх Байнгын хороодын хурал тавигдаж байгаа. Бүх Байнгын хороодоор төсөв, төсвийг дагаж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг бүхлээр нь авч хэлэлцэнэ. Байнгын хороо тус бүр хэлэлцэнэ.

Ингээд нэг дэх өдөртөө багтааж Байнгын хороодын санал, дүгнэлт гарна.

Хоёр дахь өдрийн үдээс өмнө ажлын хэсэг Байнгын хороодоос гарсан санал, дүгнэлт, Улсын Их Хурлаас гишүүдээс гарсан санал, дүгнэлтийг нэгтгэх ажлыг зохион байгуулна.

Мягмар гарагийн үдээс хойш Төсвийн байнгын хороо хуралдаж Байнгын хороод болон ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэж, санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулж, нэгтгэлийн ажлыг бүрэн гаргахаар төлөвлөж байна.

Ингээд ирэх Лхагва гарагт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан зарлагдаж төсвийн хоёрдугаар хэлэлцүүлгийг хийнэ.

Лхагва гарагтаа багтаж хоёрдугаар хэлэлцүүлгээ бид хийж дууссан тохиолдолд тэр шөнөдөө Байнгын хороод эргэж хуралдаж бэлтгэл хангаад, Пүрэв гарагт төсвийн хэлэлцүүлгийн гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгийг хамтад нь зохион байгуулъя гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа.

Өчигдөр хуралдсан төсвийн нэгдүгээр хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын гишүүдийн хувьд 45 гишүүн асуулт асууж, хариулт авсан, 9 гишүүн үг хэлж, үзэл бодлоо илэрхийлсэн.

Тэгэхээр энэ бүх зүйлийн нэгтгэл ирэх өдрүүдэд ингээд зохион байгуулагдана гэдгийг Улсын Их Хурлын гишүүдэд мэдээлж хэлье.

Тэгээд гишүүд өөрсдийн санал, зарчмын зөрүүтэй саналуудыг ажлын хэсэг болон Байнгын хороод дээр идэвхтэй гаргаж, ажлын хэсэг болон Байнгын хорооныхоо хуралдаанд идэвхтэй оролцохыг Та бүхэндээ сануулж хэлэхийг хүсэж байна.

Бидэнд цаг хугацаа бага байна. Орон нутгийн түвшинд, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төсвөө хэлэлцэх гээд цаг хугацаагаа товлосон, хүлээсэн ийм байдалтай байж байгаа гэдгийг та бид бүгдээрээ мэдэж байгаа.

Мэдээж Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлтэй холбоотой асуудлаар энэ саналууд эцэслэн шийдэгдсэний ард дээр бид аль болох хурдтай ажиллаж, богино хугацаанд орон нутагт төсвийг хүргүүлэх ажлыг зохион байгуулах ийм үүрэгтэй байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Ингээд ер нь Улсын Их Хурлын намрын чуулган хуваариараа 01 дүгээр сарын 15-ны өдөр завсарлахаар хуваарьтай байгаа. Хуралдсан тоогоороо тэрнээс нааш завсарлах нөхцөл үүссэн байгаа.

Яагаад гэхээр бид ээлжит бус чуулган зохион байгуулсан, энэ удаагийн төсвийг дахин хэлэлцэж байгаатай холбоотой Улсын Их Хурлын хуралдааны нэгдсэн чуулган болсон тоо жишээлбэл хуульд тавигдаж байгаа шаардлагыг бүрэн хангасан ийм байдалтай байгаа.

Гэхдээ Засгийн газраас Улсын Их Хуралд том том төсөл, хөтөлбөрүүдийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэхээр өргөн барих төлөвлөгөөтэй явж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг даргын дэргэдэх зөвлөл дээр Ерөнхий сайд, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүдээс ирж байгаа саналыг үндэслэж ярилцаад Улсын Их Хурлын намрын чуулганы завсарлах хугацааг тодорхой болгоно гэсэн ийм байдалтай ажиллаж байгаа гэдгийг Та бүхэндээ хэлье.

Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна.

Индэрт урьж байна.

**Г.Уянгахишиг:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Тус хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор уг хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнээр ахлуулан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хуультай нийцүүлэх арга хэмжээг авч

хэрэгжүүлэх хугацааг 2027 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгахаар хуулийн төсөлд тусгасныг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор болгон өөрчлөн, уг өөрчлөлтийг Улсын Дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлэх, мөн хуулийн төслийн 2 дугаар зүйлд уг хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөөр заасныг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух хуваарьтай байгаа.

Ингээд улс төрийн намын бүлгүүдээс болон намын бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс нийт 9 гишүүнээс санал ирсэн байна. Асуулт асууж, үг хэлэхээр.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ Улс төрийн намын тухай хуулийг өөрчилж байгаа нь Засгийн газрын тогтвортой байх тухай л асуудлыг ярьж байгаа юм.

Өөрөөр хэлбэл 3 намын даргын асуудал яригдана.

Тэгэхээр энэ дээр мэдээж энэ засаг тогтвортой байх ёстой гэдэг энэ зарчим дээр би байгаа. Яагаад гэвэл олон томоохон төсөл, хөтөлбөрүүд явах ийм боломжийг энэ хамтарсан Засгийн газрын үед бий болгож байгаа гэж харж байгаа.

Тийм учраас дэмжиж байгаа.

Гэхдээ хамтарсан нэрээр өнгөрсөн хугацаанд харж байхад яг энэ Ардчилсан намын 8 сайд томилогдсон болохоос биш бусад ямарваа нэгэн томилгоо, энэ хамтарсан засагт тодорхой бодлогоо хэрэгжүүлэх тэр томилгоонуудын асуудал ерөөсөө явахгүй байгаа.



Өөрөөр хэлбэл Ардын намын тэр дунд шатад ажиллаж байгаа тэр бүх хүмүүс бүгдээрээ өнөөдөр байр сууриндаа байж байна. Зарим сайдын ажлыг гацааж байна. Ардчилсан намын энэ бодлогыг хэрэгжүүлэх ёстой тэр хүмүүс гудамжинд явж байгаа.

Тэгээд дунд шатдаа бүгдээрээ яг энэ засгийн ажлыг гацаасан, тэр хулгай зэлгийгээ хамгаалсан ийм зүйлүүдийг маш их хийж байна.

Сайд нар дээрээ хамтарчихсан мөртөө доошоо албан тушаалтнуудыг ерөөсөө томилох тэр асуудлыг ерөөсөө хийхгүй байгаа. Энэ чинь бодлого дирдлагатайгаа зэрэгцээд хамтдаа явах ёстой байхгүй юу.

Тэр дунд албан тушаалтнууд бүгдээрээ бараг л дунд хуруугаа манай нам руу гаргачхаад байж байгаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэс Эм Жи Эл энэ тэр гээд олон төрийн өмчийн компаниуд дээр томилгоо хийдэг.

Өөрөөр хэлбэл тэр төрийн өмчийн компаниуд дээр өнгөрсөн хугацаанд ямар их хулгай гарсныг, ямар их тэр сонгуулийн зардал тэндээс гарсан тэр бүх зүйлийг бүгдээрээ би энэ хамтарсан засгийн үед хамтарч байж тэр эрх мэдлийн хуваарилалтын дагуу энэ асуудлыг шалгаж тогтоож, цаашдаа энэ төрийн өмчийн компанийн менежмент илүү шударга, үр ашигтай байх тэр ажлыг хийх ёстой байхгүй юу даа. Түүн дээрээ бүгдээрээ зогсчихсон ийм байдалтай байгаа.

Тийм учраас энэ дээр ялангуяа ялсан аймгууд байна. Тэнд чинь аймгийн дирдлагууд тодорхой хэмжээгээр бодлогоо гаргаад тэр бодлогынхоо дагуу тухай тухайн салбарт үйл ажиллагаагаа явуулаад илүү хурдтай ажиллах ёстой. Гэтэл энэ дээр нь бүх сайдууд бүгдээрээ тээг тавиад сууж байна. Ийм байдлаар хамтрахгүй ээ.

Дээрээс нь манай Ардчилсан намын институцлаг тэр байдлыг бүгдийг нь устгаж байна. Өөрөөр хэлбэл ямарваа нэгэн томилгоо гарахад ганц нэгхэн хүнээр дамжиж орж ирдэг энэ зүйл чинь Ардчилсан намыг дотор нь хуваагдах ийм нөхцөл байдал руу хүргэж байгаа.

Дээрээс нь сайд нарыг томилохдоо хэдэн хүний гарын үсэг аваад ир гэдэг ийм хачин увайгүй өөрсдийгөө дотор болдог ийм зүйлийг манай нам руу оруулж ирж энэ намын дотоод үйл ажиллагаанд хортой нөхцөл байдал бий болгож байгаа шүү гэдгийг анхаарах ёстой.

Тийм учраас энэ хамтарсан бол хамтарсан шиг хамтар.

Тэгээд хуулиар манай намын асуудлыг шийдчихдэггүй шүү гэдгийг хамгийн эцэст нь хэлье.

Манай нам энэ хуультай чинь хуульгүй чинь энэ намынхаа асуудлыг шийдвэрлээд явах бүрэн боломжтой нам гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлэх нь байна.

**О.Цогтгэрэл:** Энэ Улс төрийн намын тухай хууль дээр Ардчилсан нам болоод Ардчилсан намын бүлгийн байр суурь, Ардчилсан намын бүлгээс тодорхой байр сууриуд гарсан.

Зарчмын хувьд энэ Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилтийг хойшлуулах нь хуульд хэрэгжээд явж байхад нь өөрчлөлт оруулах нь буруу гэдэг байр суурийг Ардчилсан намын бүлгээс илэрхийлсэн. Байр суурь нэгдсэн.

Улсын Их Хурлын хууль тогтоомж өөрөө олонхоороо гардаг. Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэх дээр энэ хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэдэг олонхын санал гарсан учраас үргэлжлээд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа.

Ажлын хэсгээс хугацааг тодорхой хэмжээгээр нэлээн хугацаагаар наашлуулъя, нэг жилийн дотор гэдэг өөрчлөлтийг оруулъя гэдэг ажлын хэсгийн хугацаа гараад ажиллаж байна. Энэ дээр би ажлын хэсэгт орж ажилласан гишүүний хувьд байр сууриа илэрхийлэх нь зүйтэй.

Дахиад дээрээс нь энэ хуулийг хойшлуулах нь буруу гэж тодорхой байр сууриудыг илэрхийлж байсан гишүүний хувьд илэрхийлэх нь зүйтэй гэж бодож байна. Мэдээж Улсын Их Хурлын шийдвэр олонхоороо гараад явдаг.

Тэгээд тодорхой хэмжээний ойлголцол, зөвшилцөл энэ дээр хийгдээд явж байгаа. Яг энэ хуулийг хэрэгжүүлэх хугацаанд тодорхой тийм асуудлууд энэний цаана байгаа.

Жишээ нь, энэ хуулийн хэрэгжүүлэлт дээр Улс төрийн намын тухай хуулийн дотоод зохион байгуулалтыг тодорхой хугацаанд хуульд нийцүүлэх гэж байгаа юм.

Дотоод зохион байгуулалт гэдэг яг юу гэсэн үг вэ гэдгийг асуухаар манай ажлын хэсэг болоод дэд ажлын хэсэг хууль санаачлагчийн зүгээс тодорхой хариултуудыг хэлэхгүй байгаа юм. Дотоод зохион байгуулалт гэдэг нь бүтэц юм уу, бүрэлдэхүүн юм уу, бүгдээрээ юм уу, яг юуг ойлгох юм гэдэг асуудал.

Жишээ нь, Улсын дээд шүүхэд өөрчлөлтөө хийгээд дотоод зохион байгуулалтын хамт өөрчлөлтөө хүргүүлнэ гэдэг өгүүлбэр хууль дээр явж байгаа. Улсын дээд шүүхэд эхлээд бүртгүүлчхээд дараа нь энэ өөрчлөлтөө өгөх юм уу, Улсын дээд шүүхэд нам дүрмийн өөрчлөлтөө дотоод зохион байгуулалтын өөрчлөлттэйгөө өгөх юм уу гэдэг энэ өөрөө салаа утгатай.

Тэгэхээр хуульд ийм аливаа салаа утгууд байгаад байхаар энэ өөрөө тэр хуулийг хэрэгжүүлэгчдэд, төрийн албан хаагчдад нэгдүгээрт нь хүндрэлтэй.

Хоёрдугаарт, нь энэ хуульд салаа утга байхаар үүнийг хоёрдмол утгаар ашиглаж болдог. Улсын дээд шүүх дээр ийм жишээнүүд маш их олон гарч байсан. Бид Ардчилсан намын хувьд 2020-2024 оны хувьд үнэхээр Улсын дээд шүүх улсын бүртгэлтэй холбоотой олон олон тийм маргаан мэтгэлцээн гарч байсны хувьд бид бүгд үүнд санаа зовниж байгаа.

Ийм учраас тодорхой хэмжээний энэ хууль зүйн дүгнэлтүүдийг гаргах ийм хэрэгцээ шаардлагууд энд байна уу? Үүнийг Улсын Их Хурлын тамгын газрын зүгээс энэ хоёрдмол утгыг тодорхой хэмжээнд хуулийн хэлэлцүүлгийн явц болоод протокол дээр энэ бүгдийгээ их тодорхой тусгаж, хууль хэрэгжүүлэгчдэд энэ дээр тодорхой чиглэлүүд нь тодорхой байвал хойш хойшдоо энэ хуульд нь их чухал юм болов уу гэж үзэж байгаа энэ санаануудаа ч бас ингээд ажлын хэсэг дээр хэлж илэрхийлээд явж байгаа.

Тэгээд тодорхой түвшинд улс төрийн ойлголцол, зөвшилцөл гараад явж байгаа. Үүнийг бүлгийн гишүүдэд эргэж танилцуулаад энэ ойлголцол зөвшилцлүүд гараад явж байгаа гэдгийг ажлын хэсгийн гишүүний хувьд төгсгөлд нь хэлье.

**Д.Амарбаясгалан:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Монгол Улсын хөгжилд энэ улс төрийн намуудын төлөвшил чухал үүрэг роль гүйцэтгэдэг.

Тэгээд өнгөрсөн онд батлагдсан Улс төрийн намын тухай хуулиар яг энэ ил тод болох, илүү шинжлэх ухаанч болох чиглэлийн нэлээн олон заалтуудыг сайжруулж оруулж ирсэн байгаа.

Тэгээд энэ өөрчлөлтийг хэрэгжүүлэх хугацааг өргөн барьсан төслөөр болохоор улс төрийн шинжтэй, сонирхлын зөрчилтэй байж магадгүй өнгө аяс байсан. Ерөнхийлөгчийн сонгуулийн цаг хугацаатай ойрхон байсан учраас үүнийг хэрвээ өөрчлөх зайлшгүй шаардлагатай бол богино хугацаагаар өөрчилье гэсэн ийм саналтай байсан.

Гэхдээ энэ оруулж ирсэн томъёолол дээр энэ хугацааг ирэх оны 12 сарын 31-ний дотор гэж оруулж ирсэн байна.

Тэгээд энэ саналыг дэмжиж байгаа. Үүнтэй холбоотой асуулт асууя гэж бодож байсан.

Тэгэхээр энэ санал ирэх жилдээ гээд ороод ирсэн учраас асуух асуулт алга. Тэгээд саналыг дэмжиж байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Чинбаатарын Анар гишүүн асуулт асууя.

**Ч.Анар:** Өглөөний мэнд. Эрхэм гишүүд ээ.

Энэ улс төрийн намын хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулахыг би ер нь 100 хувь эсэргүүцэж байгаа. Их Хурал хууль тогтоох дээд байгууллага нь хуулиа гаргачхаад, тэгээд улс төрийн шинж чанартайгаар бид бойжоогүй байна гээд үүргээ биелүүлэхгүй болоогүй байгаа учраас ингээд хуулийнхаа хэрэгжилтийнхээ наана нь хуулиа өөрчилье гээд орж ирдэг.

Тэгээд ерөөсөө ийм олон хуулийн өөрчлөлтүүд ингээд байнга байнга орж ирж байдаг. Тэгээд энэ чинь өөрөө парламентын итгэлцэл гэдэг асуудлыг яриад байдаг. Нэгд.

Хоёрдугаарт, тэгээд энэ хуулийн өөрчлөлтийг зөв санаачилгатай хууль гаргачхаад хойшлуулж байгаа нь цэвэр улс төрийн шинж чанартай.

Тэгэхээр энэ нь анхнаасаа зарчмын хувьд ер нь дахиж ийм олон хуулиудыг өөрсдөдөө тааруулж оруулж ирмээргүй байна.

Тэгээд өнөөдөр яах вэ, энэ ажлын хэсэг ажиллаад энэ эмэгтэй гишүүд маань ахлаад энэ хойшлуулах хугацааг нэг жилээр хойшлуулж байгаа нь маш сайн авууштай хэрэг байна. Тэгээд энэ санаачилгыг гаргасан ажлын хэсгийн гишүүд, нийт уриалсан энэ гишүүддээ баярлалаа гэж хэлье.

Ер нь цаашдаа улс төрийн зорилготой хууль өөрчилдгийг ерөөсөө хэрхэвч дэмжмээргүй байна. Харилцан тохиролцож байгаад дэмжсэн процесс явж байгаа шүү дээ.

Тэгээд ард түмнийг болохоороо хуулиа хэрэгжүүлэхийг шаардахдаа маш сайн мөртлөө өөрснөө хуулиа хэрэгжүүлэх дээрээ гарц гаргалгаа олохдоо их гарамгай юм байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Өнөөдөр Ардчилсан намын ойн баярын өдөр бүгдээрээ Улс төрийн намын хуулийн анхдугаар хэлэлцүүлэг хийж байна.

Тэгээд энэ жил хэрэгжих ёстой байсан дүрмийг шинэчлээд бүтэн жилээр хойшлуулж байгаа. Тэгээд дараа жилийн өдийд дахиад үүнийгээ хойшлуулъя гээд дахиад унжганасан байдалтай юм орж ирэх вий дээ гээд би санаа зовж байгаа.

Ер нь тийм учраас ингэж болохгүй.

Тийм учраас миний хувьд энэ протокол бүр тэмдэглүүлмээр байна. Энэ ирэх жилийн өдийд дахиад энэ хуулийг хойшлуулъя дахиад ингэе гэсэн дотроо

асуудлаа шийдэж чадахгүй орж ирэхгүй байх талаас нь Ардчилсан намынхан маань анхаарч өгөөсэй гэж би хүсэж байгаа юм.

Болж өгвөл энэ ирэх жилдээ багтаад намууд бүгдээрээ шинэчлэгдээд дүрмээ шинэчлээд тэгээд явах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд бүтэн жил гэдэг чинь хангалттай урт хугацаа шүү дээ. Тэгээд хойшлуулж байгаа болохоор манай Ардчилсан намын нөхдүүд маань ирэх жилийн өдийд 12 сарын 06-ны өдөр, 2025 оны 12 сарын 06 гэхэд бүх юмаа сайхан хийчихсэн, тэгээд энэ улс төрийн намынхаа шинэ хуулийг мөрдөөд явж байх нь зөв байх гэж бодож байна.

Ер нь би тэгж ойлгож байгаа шүү дээ. Би тэгж л ойлгож байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Яах вэ, хэдүүлээ улс төржөөд яах вэ. Ярих юмаа ярих Байнгын хороо, ажлын хэсгүүд дээр нэлээн яриад энэ улс төрийн намууд хоорондоо зөвшилцөөд явж байгаа гэж ойлгож байгаа.

Ардчилсан намд зориулсан өөрчлөлт гэж ерөөсөө эхнээсээ энэ Засгийн газар ч тэгж өргөн бариагүй.

Өнөөдөр энэ улс төрийн намууд, парламентад суудалгүй намууд цаашдаа хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл хугацаанд шахагдаад хүнд болчихлоо. Парламентад орсон хэдэн намууд нь ороод хаалгаа хаагаад, бусад намуудыг татан буулгах нөхцөл рүү оруулчихлаа гэдэг ийм үндэслэл бас улс төрийн намуудаас Засгийн газарт шаардлага ирсний үндсэн дээр энэ асуудал яригдаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр бид энэ танхим дотроо хамаагүй улс төржилт хийгээд яах вэ.

Ер нь улс төрийн намууд өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, хүчин төгөлдөр байгаа намын дүрмийнхээ дагуу энэ хурал, зөвлөгөөн, бусад зүйлээ зохицуулах, хийх бүх нөхцөл боломж нь нээлттэй байгаа гэдгийг манай гишүүд маань эрх биш мэдэж байгаа байх гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Сайнбуйангийн Амарсайхан Шадар сайд асуулт асууж, үг хэлье.

**С.Амарсайхан:** Би үг хэлнэ.

Нэгдүгээрт, энэ Улс төрийн намын тухай хууль, дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал энэ ардчилсан Монгол Улсын улс төрийн тулгуур багана, тогтолцоог шинэчлэх, сайжруулах, улам боловсронгуй болгоход их чухал үүрэгтэй гэж үзэж байгаа.

Энэ хүрээнд нэгдүгээрт энэ хуульд өөрчлөлт орсноор улс төрийн намуудын улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх боломж бүрдэнэ. Ийм зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа.

Хоёрдугаарт, улс төрийн намуудын, ялангуяа санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох, цаана нь нуугдмал байдаг элдэв хардлага, сэрдлэг дагуулсан авлига, хандив тусламжийн асуудал гээд байнгын яригдаж байдаг зүйлүүдийг ил тод болгох.

Гуравдугаарт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар улс төрийн үйл ажиллагааг илүү төлөвшүүлэх ийм шаардлагын хүрээнд хийгдэж байна гэж харж байгаа юм.

Тийм учраас улс төрийн намуудын дотоод зохион байгуулалт, санхүүжилт, үйл ажиллагааны ил тод байдал, тэр өөрөө тэр хүрээндээ хүссэн хэмжээнд ил тод бус байгаа асуудал өөрөө улс төрийн итгэлцэл, иргэд, улс төрийн намын институцийн хооронд алдагдахад хүрч байгаа ийм асуудлууд байгаа.

Зарим гишүүдийн хэлж байгаа үгнээс ч гэсэн өнөөдөр энэ танхимд ажиглагдаж байгааг Та бүхэн анзаарч байгаа байх.

Тэгэхээр хаана хаанаа энэ асуудлуудаа ойлголцоод, тэгээд хугацаагаа сунгаад, энэ өөрчлөлтөө хийгээд явах нь зөв өө.

Энэ хуулийн шинэчилсэн найруулга нь намуудын үйл ажиллагаанд ил тод байдлыг илүү бий болгоно. Хариуцлагын тогтолцоог ч нэмэгдүүлэх шаардлагатай. Олон нийтийн итгэлийг сэргээх нэг чухал ийм алхам болно гэж бодож байгаа.

Ингэж байж энэ улс төр төлөвшиж, төр төвшин байх боломж нөхцөлийг хаана хаанаа бүрдүүлнээ. Нөгөө талдаа өнөөг хүртэл энэ намуудын санхүүжилт, сонгуулийн үйл ажиллагаа, компани ажлын зардал хэт өндөр байна, эсвэл ил тод бус байна гэдэг ийм ярианууд явж ирсэн.

Тэгвэл үүнийгээ ч гэсэн энэ хугацаанд тодорхой болгоод, нэгэнт Улс төрийн намын тухай хуулиар бид санхүүжилт авдаг болсон учраас намууд нөгөө талдаа хаанаас, хэнээс ямар санхүүжилт авч байгаагаа ил тод бүр нэг нэгэнгүй гаргадаг байх энэ тогтолцоогоо тодорхой болгох ёстой.

Санхүүжилтийн эх үүсвэрийг ил тод, хяналттай болгож, улс төрийн орчинд шударга байдлыг бий болгох юм бол тэр хэрээрээ энэ улс төрийн намуудын үйл ажиллагаа ойлгомжтой бөгөөд илүү идэвхтэй явах боломж бүрдэнэ.

Хамгийн сүүлд энэ төрийн тогтвортой байдлыг хангахад энэ Улс төрийн намын тухай хууль чухал шүү. Төр гэж байгаа цагт улс төрийн нам байна. Улс төрийн нам байгаа цагт төрийн бодлого хэрэгжиж явдаг ийм бичигдээгүй хуультай.

Тэгэхээр энэ цаг үед энэ гадаад, дотоод орчин нөхцөл ямар байгаа билээ. Дотооддоо бид төсөв хөрөнгөө батлахаас эхлээд үл ойлголцлууд, элдэв янзын буруу зөрөө ойлголцлууд ихээхэн явж байгаа.

Тэгэхээр энэ төрийн бодлого шийдвэрүүд, залгамж чанар, тогтвортой байдлаа хангах замаар энэ улс орны ирээдүйн хувь заяатай холбоотой олон асуудал дээр улс төрийн намууд зарчмаа тодорхойлох ёстой. Бүр нарийн ярих юм бол энэ хугацаанд үзэл баримтлалаа хүртэл шинэчилж, илүү ойлгомжтой тод томруун болгох хэрэгтэй.

Яг ямар үзэл баримтлалтай аль нам нь ямар байр суурийг илэрхийлж энэ нийгмийн асуудлуудыг, улс төрийн хандлагуудыг бий болгох гээд байна вэ гэдэг хүртэл сүүлд ер нь ойлгомжгүй болчихоод байгаа шүү дээ.

Тийм учраас энэ намуудын үйл ажиллагаа тодорхой хариуцлагатай, мэргэжлийн түвшинд, улс төрийн мэргэжлийн түвшинд явагдах, тэр хэрээрээ төрийн бодлого тунгалаг бөгөөд тогтвортой хэрэгжихэд энэ Улс төрийн намын тухай хууль өөрөө чухал үүргийг гүйцэтгэнэ. Үүнийг зүгээр.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар асуулт асууж, үг хэлье.

**Б.Батбаатар:** Улс төрийн намын тухай хуулийг бид ер нь дахиж нэг харж үзэх ёстой байгаа юм.

Эрх баригч 3 нам 118 өнөөдөр бүлэг үүсгэчихсэн байгаа энэ нөхдүүд өнгөрсөн парламентаар 2023 онд баталсан. Батлахдаа өөрсдөдөө зориулсан хууль баталсан.

Улс төрийн намыг иргэдэд боломж олгодог, иргэдийн оролцоотой байдаг тэр нөхцөлийг нь харьцангуй бүрдүүлсэн, тэр боломжийг нь хаалттай болгосон ийм л хууль байгаа гэж ойлгож байгаа. Бусад улс төрийн намуудын санал санаачилгыг гүйцэд сайн аваагүй.

Тийм болохоор Дээд шүүх дээр бүртгэж байгаа энэ бүртгэлийг л хойшлуулах тухай төсөл санаачлагчийн оруулж ирсэн нь тийм л зүйл байгаа шүү дээ.

Түүнээс биш Улс төрийн намын тухай хуульдаа гар хүрээд байгаа юм байхгүй байгаад байгаа юм. Дээд шүүх дээр улс төрийн намууд бүртгүүлэхэд хэд хэдэн асуудлууд үүсдэг шүү дээ.

801-ээс дээш хүний санал санаачилгаар улс төрийн нам байгуулна гэхээр мянган хүн байж болдоггүй. Заавал 801 гарын үсэг байдаг. Энэ бүртгэлтэй холбоотой одоо жишээ нь сая бид Дээд шүүхэд материалаа хүргүүлчихсэн л дээ. Манай Үндэсний зөвлөлийн хороо тэд хүртэл гэдэг тоотой байхад заавал тэд гэдэг тоо тавь гэж байгаа юм.

Тэгэхээр энэ улс төрийн намын тухай бүртгэлийн тэр Дээд шүүхээс гаргаж байгаа журмыг бид ер нь процессынхоо хувьд хуульчилж өгөхгүй бол бас болохгүй юм байна лээ. Цаашдаа энэ Улс төрийн намын тухай хуулийг ингээд бүртгэлийнх нь хугацааг нь хойшлуулъя гэхээр татвараа төлж байгаа компани татвараа төлөхгүй хойшлуулъя гэдэгтэй адилхан эрхийг нь өгөх ёстой гэж яриад байгаа юм. Үгүй шүү дээ. Энэ чинь бид иргэдэд боломжийг нь л олгож байгаа шүү дээ.

Улс төрийн эрхээ эдлэх. 0.07 га газрыг иргэдэд өмчлүүлэх хугацааг бид арван хэдэн жил сунгаж өгсөн шүү дээ. Тэр нь иргэд хариуцлагатай, хариуцлагагүй байна гэж яриагүй. Иргэдийнхээ эрхийг нь, боломжийг нь бүрдүүлж өгье өө гэдэг утгаар л хойш нь суух хугацааг нь сунгаж өгсөн шүү дээ. Түүнтэй адилхнаар ойлгомоор байгаа юм.

Тэгэхгүй ингээд өөрсдийнхөө дотоод асуудлуудыг нааш нь оруулж ирж шийддэг юм уу, шийдүүлдэг юм уу, ийм механизмаар хийж байна гэдэг ойлголтоороо яваад баймааргүй байгаа юм.

Тэр Улс төрийн намын тухай хуулийн санхүүжилт гээд яриад байгаа юм. Уг нь бид ардчилсан улс орон юм бол улс төрийн намын гишүүнчлэлийг ил тод, нээлттэй болгох хэрэгтэй. Аль намын гишүүн байна гэдгээсээ нуугдаж хаагдаж байх шаардлага байхгүй шүү дээ.

Тэр нам гишүүд нь намын гишүүнчлэлтэй байснаараа хүн амын орлогын албан татвар гэдэг шиг өөрийнхөө орлогоосоо нэг хувийн татвар төлж намаа санхүүжүүлдэг энэ рүүгээ очих хэрэгтэй юм байгаа юм. Гишүүний хувьд татвар төлдөг.

Татвар өлөгчдийн мөнгөнөөс энэ улс төрийн намыг санхүүжүүлдэг энэ байдал тийм зөв зүйл биш. Улс төрийн намыг төлөвшүүлэх, бойжуулах тэр талдаа сайн гэж байгаа боловч ер нь зарчмын хувьд бид гишүүдээсээ татвараар санхүүждэг тэр чиглэл рүү нь. Тэр нь тэгээд нээлттэй. Бүх гишүүд нь аль намын гишүүнчлэлд байгааг нь нээлттэй байдаг. Улсын бүртгэл дээр тэр нь байдаг. Ардчилсан улс оронд энэ бол хүний эрхийн хувьд асуудал байхгүй зүйл шүү дээ. Энэ рүүгээ явмаар байгаа юм.

Тийм болохоор хугацаа хойш нь сунгах тухай төсөл санаачлагчаа саналыг нь дэмжиж байгаа. Ажлын хэсэг нь тэгээд дахиад л 3 намын төлөөлөл орчихсон байж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Тэгээд өнөөдөр ардчиллын төлөөх 5 нам нэгдсэн өдөр. 24 жил болж байна. Яг энэ ордонд 24 жилийн өмнө хурал хийж байсан. Тэр хуралд миний бие оролцож байлаа.



Тэгээд бүх энэ Ардчилсан намын гишүүд болон дэмжигчдэдээ энэ завшааныг ашиглаад баярын мэнд хүргэе. /алга ташив/

Улс төрийн намын тухай хууль маш чухал. Бүгдээрээ түрүүн үгэндээ хэллээ.

Тэгээд хоёр асуудал байна л даа. Улс төрийн намын тухай хууль нь өөрөө хэрэгжээд эхлэхийн ач холбогдол юу вэ гэхээр чинь энэ хууль бүхэлдээ комплекс болж хэрэгжих юм байна лээ.

Тэгэхгүй гэвэл одоо бас зөрчилтэй асуудлууд зөндөө үүснэ. Жишээлбэл, судалгааны төв байгуулсан байх ёстой. Байгуулсан юм уу? Бас дахиад харьяа байгууллагууд нь бүртгүүлчихсэн байх ёстой юм байна лээ. Бүртгүүлсэн юм уу? Тэгээд энэ байгууллагууд нь санхүүжилтээ тодорхой тодорхой хувиар авах ёстой.

Тэгэхээр энэ байгууллагууд нь дүрмийнхээ дагуу байгуулагдаагүй юм бол санхүүжилтээ авч чадах юм уу? Хууль зөрчөөд авлаа гэхэд буцааж өгөх хэрэг гарна. Энэ хууль маань үндсэн Улс төрийн намын тухай хууль маань хэрэгжээд бүтэн нэг аравны хагас жил болчихжээ. Нэг жил 6 сар болж байна.

Тэгэхээр бүтэн нэг жил 6 сар өнгөрсөн байхад энэ хийх ёстой ажлуудаа хийж амжаагүйнхөө төлөө Улс төрийн намын тухай хуулийн энэ чухал заалтыг хойшлуулахыг эсэргүүцэж байгаа юм.

Зарчмын зөрүүтэй санал уг нь гаргасан. Хууль санаачлагчид нь буцаах буюу энэ хугацааг нь хэвээр нь үлдээхийг хүсэж Ардчилсан намын нэр бүхий гишүүд хүргүүлсэн боловч О.Амгаланбаатар. Би нэрийг нь дурдчихъя. Д.Жаргалсайхан, Д.Ганбат гишүүн, С.Эрдэнэболд гишүүн, миний бие хүргүүлсэн боловч ажлын хэсгийн санал дэмжигдсэн гэдгээрээ бидний асуудлыг авч хэлэлцдэг ч үгүй юм байна. Энэ дэг бол бас жоохон тиймэрхүү л юм байна.

Тэгээд бүхэл бүтэн 1.5 жил өнгөрч байхад бүртгүүлээгүй байсныхаа төлөө хойшлуулах нь буруу гэж үзэж байгаа.

Дахиад энэ хуульчид ярьж байгаа. 41.10 буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10 дээр уг нь маш тодорхой заачихсан байгаа байхгүй юу. Хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бидний өөрчлөх гээд байгаа хууль чинь мөн үү. Хууль мөн. Монгол Улсын хууль гээд заачихсан.

Энэ хууль болон түүний зүйл, хэсэг, заалтын дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулахгүй гэж байгаа юм. Нэг ёсондоо зүйлийн дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулахгүй гэдэг чинь энэ 2 дугаар зүйлийн бидний 6 сарын дотор дүрэмдээ өөрчлөлт орж бүртгүүлээ гэсэн энэ хугацаа буюу энд өөрчлөлт оруулж болохгүй гэсэн ийм санаа гэж би бөгөөд бусад хуульчид үзээд байгаа юм.

Тэгэхээр манай ажлын хэсгийн хуульчид болохоор тийм биш ээ. Наадах чинь дагаж мөрдөх гэдэг бол энэ хуулийгаа дагаж мөрдөх тухай асуудал яриад байгаа юм гээд байгаа боловч зүйлийн хугацаанд өөрчлөлт оруулж болохгүй гээд уг нь биччихсэн л байгаа юм л даа.

Тэгээд одоо цагаан дээр хараар бичсэн юмыг хүмүүс өөрөөрөө тайлбарлаад байгааг гайхаад байна л даа.

Тэгээд саяхан энд сонгуулийг дүгнэсэн төрийн бус байгууллагууд улс төрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын хурал болсон байна л даа.

Тэгээд тэр хуралд оролцсон Нээлттэй нийгэм хүрээлэнгийн ажилтан Б.Энхцэцэгийн ярилцлагыг би хэд хоногийн өмнө уншсан юм. Тэгээд түүн дээр ноцтой л зүйл яригдсан байна.

Улс төрийн намуудын нөхцөл байдал ер нь ямар байгаа юм. Сөрөг хүчин сөрөг хүчнийхээ ажлыг хийж чадаж байгаа эсэх. Ер нь Монгол Улсад ардчилал ухарч байна уу, урагшилж байна уу гэдэг асуудлыг хүртэл ярьсан байна.

Тэгэхээр энэ улс төрийн нам гэдэг чинь ерөөсөө олон нийтийн хүсэл сонирхлыг нэгтгэж илэрхийлэх ийм гол байгууллага.

Тэгэхээр олон нийтийн саналыг аваагүй. Энэ чинь яаралтай горимоор хэдхэн хоногийн дотор оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл дахиад хууль зөрчигдсэн. Дэгийн тухай хуулийн байна уу, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дээр олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулаад тэр гаргасан саналыг нь хавсаргаж товьёг болгож өгнө гэж бичсэн боловч энэ бол.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ж.Баярмаа гишүүн юу гэнэ ээ? Минут нэмж авъя гэсэн үү? 1 минут.

**Ж.Баярмаа:** Үгүй. Одоо тэгээд хэнээс ч юу гэж асуух вэ? Би урьд нь үгээ хэлчихсэн шүү дээ. Юм асуухаар тэгээд л гөлөг төөрүүлж байгаа юм шиг ингээд л төөрүүлээд л. Яг нөгөө еэвэнгийн хоёр тал шиг юм болгоод л өнгөрдөг шүү дээ. Тэгэхээр нэг асуугаад байх ч юм алга л даа.

Тэгэхээр ер нь бид өөрснөө хууль тогтоох байгууллага. Хууль тогтоохоос гадна хэрэгжилтэд нь хяналт тавих ийм чиг үүрэгтэй байгууллага мөртлөө хуулиа ингээд зөрчөөд байна. 38-ыг зөрчсөн. энэ 41.10-ыг зөрчиж байна.

Миний бодлоор хүмүүс үүнийг Үндсэн хуулийн цэцэд өгөх байх. Тэгээд тэр үед бид маань гэмших байх.

Хоёрдугаарт, Ардчилсан намаас явуулж байгаа гээд байх юм. Тэгээд Ардын намынхан дэмжихгүй байгаа юм бол энэ олонхоороо тэгээд дэмжихгүй гээд кнопоо дарах хэрэгтэй шүү дээ. Ардчилсан намын төлөө ингээд та нар аймаар хайртай болчихоод л. Тийм ээ. Ингээд л дэмжээд л хүчинд автаад байх шаардлага байхгүй шүү дээ.

Юун төлөө олонх билээ. Тэгээд өөрийнхөө хүсэл сонирхолд нийцүүлээд кнопоо дарах бүрэн эрх чинь байгаа шүү дээ. Тийм. Тэгээд Ардчилсан намын нэрийг барьж Ардын нам ийм үйлийг хийж болохгүй байх.

Цаана нь Ардын намын л сонирхол байгаа шүү дээ. Магадгүй Ардчилсан нам.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Төрийн байгуулалтын байнгын хороо болон ажлын хэсгийг төлөөлж Гончигдоржийн Уянгахишиг гишүүн хариулт хийнэ.

**Г.Уянгахишиг:** Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-тай холбоотой тайлбар өгье.

Тэгэхээр энэ нь болохоороо ер нь хуулийн дагаж мөрдөх хугацаатай холбоотой заалт байгаа.

Тэгэхээр тэр хуулийн зүйл, заалт, дэд хэсгийн дагаж мөрдөх хугацааг өөрчилж болохгүй гэж байгаа байхгүй юу.

Тэгвэл бидний ярьж байгаа заалт болохоороо дагаж мөрдөх журмын тухай хуулийн нэг заалт буюу энэ хуулийг хэрэгжүүлэх хугацаатай холбоотой зохицуулалт.

Түүнээс биш яг энэ хуулийг дагаж мөрдөх хугацаатай холбоотой биш. Энэ тухайн заалт дээр хэрвээ тусгайлан дахиад дагаж мөрдөх хугацаа гэж тавьсан байсан үүнийг энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-аар өөрчилж болохгүй.

Энэ нь өөрөө хуулийн өөрийнх нь зохицуулж байгаа гол асуудлынх нь агуулга нь байгаа учраас энэ бол энэ Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчихгүй байгаа. Энэ дээр бид өмнө нь ч гэсэн зөндөө олон жишээ мэднэ. Жишээлбэл, Банкны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хугацааг бид хойшлуулж байсан, газар олголттой холбоотой дээр хойшлуулж байсан.

Энэ нь өөрөө тухайн хуулийг дагаж мөрдөх хугацаа биш байхгүй юу. Яг Улс төрийн намын тухай хууль бол дагаж мөрдөөд эхэлчихсэн. Тэр дагаж мөрдөх хугацаан дээр бид юм яриагүй. Нөгөө талаасаа журмын тухай хууль маань бас дагаж мөрдөөд эхэлчихсэн. Энэ дагаж мөрдөх хугацааг хөндөөгүй.

Тэгэхээр үүнийг яг хуулийнхаа техникийн хувьд ялгаж салгаж ойлгох ёстой. Яг энэ дээр Хууль зүйн яам ч нэг адил бодолтой байгаа, хуульчид маань ч гэсэн яг адилхан тайлбарыг өгч байгаа.

Тэгэхээр энэ дээр яг хууль тогтоомжийн хууль зөрчсөн тал дээр эргэлзээ байхгүй юм л гэж хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Агваанлуvsсангийн Ундраа гишүүн асуулт асууна.

**А.Ундраа:** Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай гээд.

Өнөөдөр яах вэ бид Засгийн газраас өргөн барьсан өөрчлөлтийг хэлэлцэж байна.

Тэгэхээр ер нь Их Хурлын хэлэлцэж байгаа асуудлуудын хамрах хүрээг харахад Засгийн газраас өргөн барихаар зөвхөн тэр өргөн барьсан өөрчлөлтийнх нь хүрээнд, зөвхөн тэр заалттай нь холбоотой хэлэлцүүлэг яваад байгаагаараа зарим утгаараа эдгээр хууль тогтоомжуудад өөрчлөлт орох, шинэ хууль хэлэлцэхэд бас тийм явцуу байдал үүсээд байна гэж харагдаж байна.

Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журам, эсвэл Улс төрийн намын тухай хуультай холбоотой хамгийн гол нийгэмд бухимдал үүсгээд байгаа асуудал бол энэ сонгуулийн зардалтай холбоотой хэсэг байгаа.

Тэгээд маш их өндөр өртгөөр сонгууль явуулах юм. Хортой үр дагаврыг яриад дуусашгүй байх.

Тэгэхээр улс төрийн сонгуулийн өртгийг бууруулах, сонгогчдод сонголт хийхэд нь илүү амар болгож өгөх, улс төрийн намын санхүүжилтыг ил тод байлгах, аль болох бага мөнгө шаардагддаг байлгах нь ардчиллын амин сүнс байгаа.

Тэгэхээр бид дараа дараагийн хуулиудыг хэлэлцэхдээ заавал Засгийн газраас өргөн барьсан хүрээнд гэхгүй Их Хурлын гишүүд өөрсдөө хууль санаачлах эрхийнхээ хүрээнд хууль боловсруулан өргөн барьж аль болох идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлбэл зүйтэй юм уу гэсэн байр суурьтай байна.

Энэ бол бас зөвхөн энэ Улс төрийн намын тухай хууль дагаж мөрдөх журмаас гадна бусад хууль тогтоомжууд дээр ажиглагдаж байна.

Тэгэхээр бид шинэчилж өөрчлөх шаардлагатай байгаа. Жишээлбэл, усны асуудал, Усны тухай хууль, тарифын асуудал, эрчим хүчний реформ. Эдгээр асуудлуудыг Засгийн газар өөр дээрээ Үндэсний хороо гээд ийм давхардчихсан бүтцүүд бий болгоод эрчим хүчний асуудлыг нь нэг Шадар сайд нь хариуцаад

тэгээд Эрчим хүчний сайд юу хариуцах гээд байгаа юм гэх мэтчилэн ингээд нэг эрх мэдлийн давхардал, хий дэмий нэмэлт бүтцүүд бий болгоод байгаа нь шийдвэр гаргах процессыг туйлын үр ашиггүй болгож байна гэж харагдаж байгаа.

Тэгэхээр энэ улс төрийн намын санхүүжилтийг бууруулахтай холбоотой, тэгээд орон нутгийн сонгуулийн асуудал, орон нутгийн өөртөө засаглах засаглалыг хэрхэн үр дүнтэй сайн байлгах талаар тодорхой алхмууд хийгдэх шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Энэ журмын талаар нэлээд хэдэн эмэгтэй гишүүд, эмэгтэйчүүдийн бүлэг 70 орчим хувь нь, 70, 80 орчим хувь нь гарын үсэг зураад, гишүүд санаачилж, энэ хуулийн хэрэгжилтийн хугацааг наашлуулахаар санал гаргасан байгаа.

Энэ дээр эмэгтэйчүүдийн оролцоог сайжруулах нь мэдээж Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь хэрэгжүүлэхтэй холбоотой.

Тойргоос сонгогдсон эмэгтэй гишүүдэд сонгогдоход хэцүү болгож байгаа нэг юм чинь мэдээж энэ улс төрийн санхүүжилттэй холбоотой. Хэт өндөр санхүүжилт шаардагдаж байгаа. Ухуулагчдын зардал гээд энэ маш их ачаалал үүсэж байгаа.

Энэ нь эргээд яадаг вэ. Эргээд сонгогдсон улс төрчид буруу зөрүү зүйл хийж тэр шархаа нөхөх гэж хэлдэг шүү дээ. Хэвлэл дээр. Тэр үйл ажиллагаа руу хөдлөөд байгаа юм биш үү гэж шулуухан хэлэхэд дүгнэж болохоор байгаа юм.

Тэгэхээр эмэгтэйчүүдийн санаачилга зөвхөн эмэгтэйчүүд энэ сонгогдчихсон байгаа 32 эмэгтэйн тухай асуудал биш. Монгол Улсын хүн амын 50 гаруй хувийг бүрдүүлж байгаа эмэгтэйчүүд, улс төрийн намуудын өөрсдийнх нь гишүүнчлэлийн суурийг харах юм бол 50-иас дээш, зарим тохиолдолд 60 орчим хувь нь эгэл жирийн гишүүд нь эмэгтэйчүүд байгаа.

Яг энэ танхимд сууж байгаа эрэгтэй гишүүддээ хандаж хэлэхэд та нарын анхан шатын ажлыг хэн хийдэг билээ, хэн голчлон нугалдаг билээ гээд эргээд нэг өрөөгөө эргэж тойруулж хараарай гэж хэлмээр байна.

Тэгэхээр хүний эрхийн асуудлыг зөвхөн өөрийнхөө жижиг аахар шаахар нарийн бичгийн даргын, эсвэл явах хамаг ажлыг нь хийлгээд тэгээд ашиг өрмийг нь хамаа ажлыг хийгээд байж болохгүй шүү.

Тэгээд зарчмын асуудлыг дотроо тунгаан бодно биз. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дарааллаар үг хэлэх гишүүд байгаа. 5 гишүүн үг хэлэхээр нэр ирсэн байна.

Өлзийхүүгийн Шижир гишүүн үг хэлнэ.

**Ө.Шижир:** Өглөөний мэнд.

Яг өнөөдөр Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 нам, Улсын бүртгэлийн ерөнхий газарт намын нэр авсан 253 нам байгаа.

Түүнээс 37 нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй гэсэн үг.

МАН, МАХН нь гэж хоёр салж байх үед Намбарын Энхбаярт МАХН нь гэдэг нэрийг өгүүлэхгүйн тулд МАХН гэж товчилж байгаа бүх нэрсийг авч байсан.

Тийм учраас ингээд 253 намын нэр болсон байхгүй юу. Тэгээд энэ Улс төрийн намын тухай дагаж мөрдөх хуулийг манай намын бүлэг дэмжээгүй л дээ.

Тэгээд манай намын бүлэг дэмжээгүй учраас би бас дэмжээгүй байр суурь илэрхийлж байгаа.

Бид өнгөрсөн 5 сарын хугацаанд 5 удаа төсөв, 3 удаа Засгийн газраас оруулж ирсэн яаралтайгаар оруулж ирсэн хууль. Одоо хэлэлцэж байгаа нь Улс төрийн намын тухай хууль болж байгаа юм.

Яг ний нуугүй хэлэхэд манай Монгол Ардын намынхан бусдын гараар могой бариулахдаа их сайн л даа. Өмнө нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр одоо энэ ХҮН намын Т.Доржхандаар хоёр удаа мэдээлэл өгөөд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихсан. Одоо дахиад ХҮН намын Г.Уянгахишиг гишүүнээр ингээд бүлтэлзүүлээд хариулт өгүүлээд энд ингээд суулгачих байгаа юм.

Монгол Ардын намын бүлэг дээр энэ асуудлыг хэлэлцээгүй. ХҮН намын зөвлөл дээр хэлэлцсэн. Манай намын бүлэг дээр дэмжээгүй.

Тэгээд цаасан дээр харагдах байдлаараа Монгол Ардын нам оролцоогүй юм шиг. Яг цаанаа захиалагч нь болчихоод байдаг. Тэгээд гурван намын сонгуульд орсон мөрийн хөтөлбөрийг харахаар бүгдээрээ л улс төрийн намуудыг гоё сайхан болгоно оо л гэсэн заалтууд байгаа.

Ардын нам дээр 2 заалт байгаа. Ардчилсан нам дээр 2 заалт байгаа. ХҮН нам дээр 1 заалт байгаа.

Хоржоонтой юм шиг ХҮН намын мөрийн хөтөлбөрт нэг ийм заалт байгаа юм.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийг батална гээд заачихсан. Хойшлуулна биш. Үйлчлэлийг хойшлуулна биш. Арга хэмжээг хойшлуулна биш. Тэгээд бүгдийг ингээд хийчихсэн.

Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт эхэлснээс хойш ингээд хоёр удаа өөрчлөлт оруулахдаа эхлээд давхар дээлийг тайлсан. Энэ Монгол Ардын намд

ашигтай байсан. Дараа нь Ерөнхийлөгчийг дахин сонгуулахгүй гэдэг юм орсон. Энэ л Монгол Ардын намд ашигтай байсан.

Тэгээд одоо ингээд дахиад л энэ үйлчлэл рүү бид орчхож байна л даа. Би зүгээр энгийн жишээ авахад сая Байнгын хороон дээр хэлсэн юм. Компаниуд бага татвар төлдөг, санхүүгийн чадамж муутай компаниуд бид энэ удаа нэмүү өртгийн орлогын албан татвараа төлж чадахгүй нь ээ. Хойшлуулж өгөөч ээ гэхээр нь уухайн тас хүлээн зөвшөөрөөд хойшлуулаад байж болохгүй л дээ. Энэ чинь бүх заалтуудыг ингээд хойшлуулдагдгаг ийм хэлбэр рүү оруулчхаж байгаа юм.

Ер нь улс төрийн нам өөрөө хугацаатай, заасан хугацаандаа хурал дүрмээ хийгээд хуульд нийцүүлэх л ёстой шүү дээ. Энэ хуулийг чинь анх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орсны дараа аль нэг нам нь Улс төрийн намын тухай хуулийг өргөн барих нь улс төрийн хувьд зохимжгүй юм байна гээд Ерөнхийлөгчөөр өргөн бариулсан юм билээ. Тухайн үедээ зөвшилцөл явагдсан гэсэн үг.

Тэгээд одоо энэ хамгийн гол заалтыг нь ингээд хойшлуулчхаж байгаа юм. Тэгээд 3.5 сая хүн амтай улсад ийм их улс төрийн нам байх нь зөв үү, буруу юу гэдгээ бид эргээд харах хэрэгтэй. Үүнийг дагасан улс төрийн намын санхүүжилтүүд ямар байр суурьтай байх ёстой гэдгийг харах хэрэгтэй.

Яг үндсэндээ сая Улсын дээд шүүхэд материалаа өгсөн 7 нам байна. Одоо хуулийн хугацаанд бичиг баримтаа бүрдүүлж өгсөн. Хойшлуулах хүсэлтэй 5 нам байна. Тэр 5 намынх нь дүрэм журмыг нь харах гэхээр интернэтэд байхгүй. Өөрийн веб сайт байхгүй. Үйл ажиллагааны тайлан байхгүй. Тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй. Тэгээд сонгууль болгоноор гарч ирдэг. Тэгээд 5 намын хойшлуулах хүсэлтийг үндэслээд гэж байгаа юм.

Тэгээд цаана нь хуулийн хугацаанд үйл ажиллагаа явуулж намуудын эрх ашгийг яагаад бодохгүй байгаа юм. Хуулийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулсан намууд яагаад энэ зүйлчлэлээр юмаа хойшлуулах ёстой юм.

Би намынхандаа хандаж хэлмээр байна. Сая Улсын Их Хурлын сонгуулиар 34 хувийн санал аваад Монгол Ардын нам ялсан. Ардчилсан нам 30 хувийн санал аваад ялагдсан. 4-хөн хувийн зөрүүн дээр.

Тэгэхээр одоо энэ засагт орсон манай 8 сайдаар Ардчилсан намын ирээдүй бас ингээд бүрхэг битгий болоосой гэж би хүсэж байна.

Тийм учраас энэ Улс төрийн намын тухай хуулийг хэдүүлээ дүрмээ. Хурал хийх чинь хоёрхон л өдрийн ажил шүү дээ. Их Хурлаа хуралдуулаад дүрэм журмаа батлах чинь.

Тэгээд энэ ийм хүндрэлтэй асуудал биш л дээ.

**Д.Амарбаясгалан:** Нэмэлт минут гэж байхгүй. Ө.Шижир гишүүн мэдээж байр сууриа хэлэлгүй яах вэ.

Гэхдээ одоо ингээд энэ Үндсэн хуулиудад орсон өөрчлөлтүүдээс дургүйгээ яриад, дуртайгаа ярихгүй байж болохгүй шүү дээ.

Хэд хэдэн удаагийн Үндсэн хуульд өөрчлөлт орсон. 2023 онд орсон Үндсэн хуулийн өөрчлөлтөөр өнөөдөр 126 гишүүн бүрдсэн. Эерэг үр дүнгээр нь та өнөөдөр жагсаалтаар гишүүн болоод орж ирээд суучихсан байж байна. Бүх юм бас муу биш. Энэ чинь цаг үеэ дагаад л өөрчлөгдөж шинэчлэгдээд явж байдаг.

Ер нь энэ Улс төрийн намын тухай хууль хэрэгжихгүй байгаа зүйл биш шүү дээ. Өнөөдөр хэрэгжиж байгаа.

Гагцхүү улс төрийн намууд, бүтэц, дотоод тэр хуулиараа хүлээсэн зохион байгуулалттай холбоотой зүйлээ хугацаандаа хийгээд Дээд шүүхэд бүртгүүлэх л асуудал.

Бусдаар энэ Улс төрийн намын хуулийн шинэчилсэн найруулга 18 жилийн дараа өргөн баригдаад маш олон олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагуудын санал, эрдэмтэд, судлаачдын оролцоотойгоор хэлэлцэгдээд, бүх намуудын оролцоог хангаад батлагдчихсан. Тэр бүх дэвшлүүд нь өнөөдөр хэрэгжээд эхэлчихсэн явж байгаа.

Тэгэхээр үүнийг айхтар туйлшруулж, зөвхөн өөрсөд дээрээ хүлээж аваад, зөвхөн намын нэг дотоод зохион байгуулалттай холбоотой асуудал мэт болгож ерөөсөө болохгүй.

Ер нь цаашдаа ер нь аль нэг нам өөрийн дотоод зовлонг төрийн зовлон болгох гэж бас улс төр хийж ярьдаг байдал ерөөсөө байж болохгүй. Бид бас энэ олон намтай, олон ургалч үзлийг, энэ ардчилыг бэхжүүлэх чиглэл дээр энэ парламент анхаарал хандуулж ажиллана. Засгийн газраас өргөн барьж байгаа хуулийн төсөл, аливаа холбогдсон асуудлыг мэдээж олон талаас нь ярилцана. Дэмжихээр бол дэмжинэ. Дэмжих боломжгүй бол дэмжихгүйгээ илэрхийлээд л явдаг. Энэ өөрөө ардчиллын л зарчим.

Тэгэхээр үүнийг заавал нэг нам руу нь нааж, нэг нам руу чихэж, ингэж улс төр болгож явах гээд байх хэрэггүй. Цаг хугацаа бүх зүйлийг засаж сайжруулж байдаг. Яг энэ хэрээр улс төрийн намууд ч гэсэн засаж сайжрах нөхцөл боломж бүрдэж байгаа гэж харж байгаа шүү.

Жуковын Алдаржавхлан гишүүн үг хэлье.

**Ж.Алдаржавхлан:** Би түрүүний хэлсэн үгэндээ манай Ардчилсан намынхан жаахан эмзэглээд байх шиг байна.



Хууль баталснаас хойш 1.6 жил дүрмээ бид шинэчилж чадахгүй байгаа. Одоо дахиад нэг жилээр сунгаж өгөх юм байна. Тэгээд энэ хугацаанд л амжаасай л гэж хүсэж байгаа юм.

Тэгээд л дахиад л дараа жилийн өдийд сунгамаар байна л гэдэг асуудал битгий яригдаасай л гэдэг санааны үүднээс би энэ үгийг хэлээд байгаа юм.

Тийм учраас дахиж сунгаж байгаа. Энэ нэг жилийн хугацаанд, сая 1.6 жилд юм хийгээгүй тэр олон намууд маань амжуулж энэ улс төрийн намынхаа шинэчлэлийг эхлүүлээсэй л гэж хүсэж байна. Тийм л зүйлийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сайнбуйангийн Амарсайхан сайд үг хэлье.

**С.Амарсайхан:** Улс төрийн намын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулж, хугацааг сунгах асуудал өөрөө түрүүн би хэлсэн.

Улс төрийн намуудыг илүү хариуцлагатай, ил тод, үйл ажиллагаа нь зарчмын хувьд шинэчлэгдсэн, иргэдийнхээ оролцоог нэмэгдүүлсэн.

Гэхдээ бодлогын институт болж хөгжих ийм боломжийг бүрдүүлсэн цаг хугацаа байгаасай л гэж л бид хугацааг сунгаж байгаа гэж үзэж байгаа.

Тэгээд энэ улс төрийн намуудын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, үнэт зүйл, тэр дундаа үзэл баримтлал нь зөвхөн өнөөдрийн энэ хугацааг сунгах, эсвэл нэг хуулийн өөрчлөлтөөр хязгаарлагдахгүй гэж бодож байна. Цаашаа ч гэсэн үргэлжлээд хийгдээд явах байх.

Гэхдээ бид өнгөрсөн хугацаанд нэлээн хэд хэдэн сонгуулийн асуудлыг, Үндсэн хуулийн өөрчлөлт, Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, тэгээд Их Хурлын сонгууль, орон нутгийн сонгууль, шинэ Их Хурал бүрэлдэх, хамтарсан Засгийн газар байгуулагдах гээд л үндсэндээ энэ улс орон сүүлийн хоёр, гурван жил нэвт улс төрөөр амьсгаллаа.

Тэгээд засаг төр байгуулагдаад Улсын Их Хурал шинээр бүрдээд нэг тодорхой хугацаанд улс төргүйгээр, улс төр багатайхан шиг энэ улс орныхоо ажил амьдралыг урагшлуулах асуудлуудаа шийдвэрлэхийн зэрэгцээ нөгөө талдаа энэ улс төрийн намуудаа илүү төлөвших, институцжих, жижиг нь ч байна уу, том нь ч байна уу, парламентад суудалтай нь ч байна уу, үгүй нь ч байна уу нэг дотоод үзэл баримтлал, үнэт зүйлийнхээ тогтолцоонд оруулах ёстой энэ асуудлуудаа цаг хугацаанд шахагдахгүйгээр энэ Улс төрийн намын тухай шинэчилсэн хуульд тусгагдсан олон асуудлуудаа нэг амьсгаагаа бүрэн авах хэмжээнд ярилцаад, алдаа оноогоо засаад, тэгээд дахиж нэг хэдэн жил гар хүрэхгүй хэмжээнд улс төрийн намын тухай хуульдаа ч, тэр намынхаа дотоод дүрэм журамдаа ч өөрчлөлт оруулахгүйгээр энэ нэг бүтээмж, тэгээд энэ ажил амьдралаа нэг улс орныхоо нэг жоохон эрүүл, тэгээд нэг эдийн засгийн өсөлт, элдэв улс төржгүйгээр хийх

ажлуудаа хоёр, гурван жил хийгээд авъя гэдэг л ийм л зорилгоор хийж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ.

Энд ямар нэгэн хүний, аль нэгэн намын эрх ашиг хөндөгдөөд айхтар амин сүнс нь төөрчих гээд байгаа юм байхгүй гэж бодож байгаа.

Одоо ингээд энэ хуулийг бид хугацааг сунгахгүйгээр шууд явах юм бол улс төрийн намууд их хурлуудаа хийнэ. Улс орон даяар бөөн улс төрийн намууд хоорондоо сайдалцсан, муудалцсан. Энэ бол одоо нуух зүйл биш шүү дээ.

Тэгээд л бөөн улстөржилт. Ингэж явсаар байгаад л дахиад л хаврын улс төрийн уур амьсгал, бүтээн байгуулалтын ажлууд гээд өчнөөн юмнуудтай зүгээр амьдралын талаас нь аваад үзвэл энд нэг яараад байх юм байхгүй байхгүй юу. Үүнийгээ сунгаад явчихад аль ч улс төрийн намд нэг тийм чичрээд байх зүйл байхгүй байх гэж бодож байгаа. Улс төрийн хийж байгаа хүмүүс улс орноо бодъё л гэж байгаа шүү дээ. Тэгээд улс төрийн нам доторх асуудлуудаа нэг жилийн дараа яриад явахад нэг их тийм болохгүй зүйл байхгүй байгаад байгаа.

Тэр дотроо харин нам дотроо судалгаагаа хийх хэрэгтэй байх. Тогтолцооны асуудлуудаа сайн ярих ёстой байх. Зарчмаа сайн тодорхойлох ёстой байх. Дүрэм журмаа сайн шинэчлэх хэрэгтэй байх.

Тэр нь өөрөө улс орон даяар судалгаа тооцоотой хийгддэг байх. Улс төрийн намын гишүүдийнхээ санаа оноог тусгадаг зарчимтай тулгуурласан байдаг байх ёстой байх гээд иргэдийнхээ намын гишүүдийнхээ оролцоог хангасан олон ажлууд та бидний өмнө байгаа байх.

Түүнээс улс төрийн нам гэдэг бол хэдхэн намын, хэдхэн дарга нарын асуудал ч биш. Хэдэн Удирдах зөвлөл, бодлогын хорооны гишүүдийн ч асуудал биш байх гэж би хувьдаа бодож байна. /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн үг хэлнэ.

**Б.Батбаатар:** Улс төрийн намын хуулийг өөрчилж байгаа асуудал ерөөсөө байхгүй.

Зүгээр л улс төрийн намыг Дээд шүүхэд бүртгүүлэх хугацааг л сунгаж өгч байгаа шүү дээ. Нэг ёсондоо иргэдийн улс төрийн эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлж байгаа ийм заалтыг л өөрчлөлт оруулж байна л гэж хараад байгаа юм.

Татвар төлсөн компани төлөөгүй компани хойш нь урагш нь болгох уу гэдэг юм яриад байгаа юм. Бид иргэдэд 0.07 га газрыг өмчлүүлэхдээ арван хэдэн жилээр хойш нь сунгаж өгсөн. Иргэдийнхээ эрх, боломжийг нь хангаж өгөхийн төлөө л хийж байсан. Түүнтэй адилхнаар улс төрийн намын хуулийн энэ хэрэгжилт нь явчихсан, эхэлчихсэн байгаа энэ хуулийн Дээд шүүх дээр бүртгэдэг бүртгэлийг нь л хойшлуулж байгаа асуудал.

Цаг хугацааны хувьд сонгуулийн бүтэн цикл давхацсан ийм хугацаанд яваад өнгөрсөн юм байна. Өнөөдөр парламентад суудалтай намууд бол бүртгэл дээр асуудал байхгүй байх л даа. Зарим нэг намууд ч гэсэн бүртгэл дээр асуудал байхгүй. Дээд шүүхэд материалуудаа өгчихсөн намууд байж л байгаа байх.

Гэхдээ парламентын гишүүд, парламентад суудалтай намууд бусдынхаа төлөө бодож хууль баталдаг баймаар байгаа юм. Өөрсдийнхөө дотоод зовлонг шийдэх гэж төрийн хуулийг баталдаг баймааргүй байгаа юм.

Доторх зовлонгоо шийдэж чадахгүй болохоороо төрийн хуулиар асуудлаа шийддэг ийм зүйл байж л байсан шүү дээ.

Өнгөрсөн парламентад бүлгийнх нь дарга нь бүлгийнхээ бүх гишүүдээ хөөчхөөд, намынх нь дарга нь намынхаа гишүүдээ хөөчхөөд тэгээд хуралдаад л шийдвэр гаргаад л яваад байгаа харагдаад л байсан.

Ер нь энэ бүртгэлийг хойшлуулж байгаа хугацааг сунгаж байгаатай холбоотойгоор Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль энэ зүйлүүдээ цэгцлэх хэрэгтэй.

Их Хурал, аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Хурал нэг өдөр сонгууль нь явдаг болох хэрэгтэй.

Гурав дахь өдөр явж байгаа сонгуулийг амралтын өдөр гэж нэрлэмээргүй байгаа юм. Ажлын өдөр болгоод тэр өдөр саналаа өгсөн хүн нь ажлаа таслаагүйд тооцогддог, цалингаа бүтэн авдаг ийм байдал руу өөрчлөх хэрэгтэй. Улс төрийн намын санхүүжилтээ ч гэсэн эргэж харж гишүүнчлэлийг нь ил тод нээлттэй болгох хэрэгтэй. 200, 300 мянган, 180 мянган, 100 мянган, 30 мянган гишүүнтэй гээд л янз бүр яриад байдаг. Ардчилсан улс оронд намын гишүүнчлэлээ нуух шаардлага байхгүй шүү дээ. Намын гишүүнчлэлээр ялгаварлагдах шаардлага байхгүй.

Намын гишүүнчлэл нь ил тод нээлттэй байгаад тэр гишүүд нь өөрийнхөө орлогын гэдэг юм уу нэг хувийн татварыг намдаа өгдөг. Татвар төлөгчдийн мөнгө улсын нийт татвар төлөгчдийн мөнгөнөөс нам санхүүждэггүй байх энэ чиглэл рүүгээ явах хэрэгтэй. Гишүүд нь ил тод, нээлттэй, нэг хувийн татвар өгдөг болох юм бол одоо намд байна гэдэг нь ашиг сонирхлын биш хүсэл зоригийн үзэл санааны зүйл болж хувирах хэрэгтэй.

Энэ чиглэл рүүгээ явахын тулд бид энэ бүртгэлийн хугацааг хойшлуулж өгөх хэрэгтэй.

Энэ хооронд бид болдог бол энэ Их Хуралд байгаа бүх намын төлөөллүүд оролцоод Их Хуралд суудалгүй ч гэсэн бусад намын төлөөлөлтэйгөө уулзаад ярилцаад иргэд сонгогчидтой яриад үүнийг өөрчлөх хэрэгтэй.

Уг нь болдог бол бүх намыг татан буулгаж байгаад дахиад нэг шинэчлэн зохион байгуулах хэрэгтэй байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Батбаярын Жаргалан гишүүн үг хэлье.

**Б.Жаргалан:** 12 дугаар сар бол Монголын ардчиллын түүхэнд, ардчилсан тогтолцооны түүхэнд онцгой ийм хувь заяа эзэлдэг.

Тэртээ 1989 оны 12 дугаар сарын 10-нд Монголын Ардчилсан Холбоо анхны цуглаанаа зохион байгуулж ардчилсан хувьсгалыг эхлүүлж байсан түүхтэй.

Өнөөдөр 12 дугаар сарын 06-ны өдөр 2000 онд ардчиллын төлөөх 5 нам нэгдэж Ардчилсан намыг үүсгэн байгуулсан тэр баярын өдрийг бас манай намын гишүүд дэмжигчид өнөөдөр тэмдэглэж байгаа.

Тэгэхээр энэ завшааныг ашиглаад ардчилал, эрх чөлөөнд хайртай нийт Монголчууддаа ардчилсан хувьсгалын 35 жилийн ойн баярын мэндийг хүргэе.

Намынхаа гишүүд дэмжигчдэдээ он удаан жил энэ ардчилал эрх чөлөөний төлөө тэмцэж ирсэн ардчилагч нартаа баярын мэнд хүргэе.

Тэгээд энэ өдөр бид Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцэж байна.

Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан. Дагаж мөрдөх журмын тухай хуулиараа нам өөрийн дүрэм, зохион байгуулалтыг энэхүү хуульд нийцүүлэн дүрэм журмаа өөрчилж шинэчлэх, Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэх ажлыг бол 6 сарын хугацаа өгсөн байгаа.

Тэгээд энэ хугацааг даруй 2 жил хагасаар хойшлуулах саналыг Засгийн газраас оруулж ирсэн. Ийм урт хугацаагаар хойшлуулахыг ерөөсөө огтхон ч дэмжихгүй байгаад байгаа.

Яагаад вэ гэхээр энэхүү Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга бол одоо өнгөрсөн парламентын үед хийгдсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Сонгуулийн тухай хуулийн тогтолцооны өөрчлөлттэй нэгэн цогц болж ирсэн. Энэ утгаараа ч Монголын ардчилалыг бас нэг аврах зорилготой нэг багц хуулийн нэг хэсэг гэж харж байгаа.

Өнгөрсөн хугацаанд Ардчилсан намыг өмнөх парламентын үед маш их зовоосон шүү дээ. Сая манай зарим гишүүд бас яриад байх шиг байна. Яг үнэндээ Ардчилсан намынхан дотроо учраа олохгүй байгаад байгаа гэхээсээ илүүтэй Улсын дээд шүүх манай намын даргыг, их хурлаараа сонгогдсон намын даргыг Улсын дээд шүүх бүртгэхгүй яваад байсны бас асуудлууд байгаа шүү.

Тэгэхээр Ардчилсан намынхан энэ асуудал дээр эмзэг хандах нь аргагүй. Яагаад гэхээр үнэхээр яг хууль ёсныхоо дагуу их хурлаараа сонгочихсон манай намын даргыг та нар бүртгэхгүй л яваад байсан.

Тэгэхээр бид энэ хуулиа шинэчилсэн. Үүнийхээ хүрээнд дүрэм журмаа цэгцлэх ажлыг зохион байгуулах ёстой. Энэ ажлыг нэн даруй аль болох эрт зохион байгуулах ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр энэ утгаараа би Ардчилсан намын гишүүний хуваариас гадна бас мөн одоо энэ Улсын Их Хурлын танхимд сууж байгаа маш цөөн тооны эмэгтэй гишүүдийн төлөөллийн хувьд давхар нэг үндэслэл хэлэх гэсэн юм.

1992 онд ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойш нийт 8 удаагийн сонгууль сая 2024 оны сонгууль хүртэлх хугацааг ярьж байгаа юм. 8 удаагийн сонгуулиар ердөө 45 эмэгтэй энэ танхимд суусан байдаг юм. Ердөө 45.

Тэгээд сая энэ тогтолцооны шинэчлэл хийсний ар дээр энэ тоо нэмэгдээд 32 гишүүнтэй болсон байгаа.

Тийм ч учраас энэ өдөр бид Улсын Их Хуралд байгаа эмэгтэй гишүүд бүгдээрээ эв санааны нэгдлээ харуулах нь зүйтэй гэж бодоод ийм ягаан өнгийн хувцсаар ижилсээд энэ өдөр хүрэлцэн ирсэн байгаа.

Яагаад вэ гэхээр Улс төрийн намын тухай хуульд ямар нэмэлт өөрчлөлтүүд орсон байгаа вэ гэхээр улс төрийн намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, хяналтын байгууллагад эмэгтэйчүүдийн оролцоог хангах маш чухал заалтууд орсон байгаа юм. /минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Б.Жаргалан гишүүндээ болон эмэгтэй гишүүддээ бас баяр хүргэе. /алга ташив/

Энэ улс төрийн намын тухай хууль Монголын парламентад суудалтай улс төрийн намууд анх санаачлаад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтарч ажиллах санамж бичиг байгуулаад эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог нэмэгдүүлэх санаачилга дээр хамтарч ажилласан.

Сонгуулийн хуулиар нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байх ёстой гэж үзсэн бол Улс төрийн намын тухай хуулиар улс төрийн намын шийдвэр гаргах түвшин дэх оролцоог 40 хувь байна гэж хуульчилсан байгаа юм. Энэ бол бас Монгол Улсын хувьд маш том амжилт. Ази, Номхон далайн бүс нутагтаа бид тэргүүлэх болсон ийм том үзүүлэлт.

Бид энэ парламентын засаглал, үүнийг бүрдүүлж байгаа улс төрийн намуудын хариуцлага, төлөвшил гэдэг энэ зүйлийн төлөө олон улсын түвшинд хөл

нийлүүлж алхах учиртай. Үүний төлөө аль ч улс төрийн нам хичээн зүтгэж байх учиртай. Гэхдээ боломжийг цөөхөн хэд нь аваад бусад нь боломжгүй болж байгаа цаг үеийг бид бас хүлээн зөвшөөрч болохгүй. Боломж гэдэг зүйл бүгдэд адилхан байх ёстой.

Тийм учраас өнөөдөр парламент бас энэ асуудлыг хэлэлцэж байгаа гэдгийг гишүүддээ дахин сануулж хэлье. Баярлалаа.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Хоёр зарчмын зөрүүтэй санал байгаа.

Санал хураалтаас өмнө эхлээд танхим дахь гишүүдийн ирцийг бүртгээдэхье. Ирц бүртгэлийн нэг санал хураалт явуулъя. Санал хураалт. Нийт 63 гишүүн танхимд байгаа юм байна. Ирц санал хураалт явуулахад бүрэн хангалттай.

Би зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя. Энэ зарчмын зөрүүтэй санал гэдэг маань Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр Байнгын хороо болон ажлын хэсгийн явцад гарсан санал байгаа.

Тэгэхээр энэ санал дэмжигдэхгүй бол анх өргөн барьсан төслөөр явна гэдгийг гишүүд маань анхаарч саналаа өгөхийг хүсье.

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “авч хэрэгжүүлэн, уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 2027 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар, О.Цогтгэрэл, Э.Одбаяр, Г.Уянгахишиг. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Булгантуяа, Х.Болормаа, Э.Болормаа, Д.Ганмаа, Б.Жаргалан, С.Замира, М.Мандхай, Л.Мөнхбаясгалан, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, О.Саранчулуун, М.Сарнай, А.Ундраа, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Д.Энхтуяа, М.Энхцэцэг гэсэн гишүүд байна.

Б.Пүрэвдорж гишүүн горимын санал гаргаж байна.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ хууль хэрэгжих хугацааг тогтоохдоо тухайн хуулийн бэлтгэл ажлыг хангах ямар ажлыг хийх ёстойг чухалчлаад, дээрээс нь

ажил хэргийн ямар мөчлөг байна, тэр бүх зүйлийг харгалзаж байж хуулийн хэрэгжих хугацааг тооцдог юм. Гаргадаг.

Тэгэхээр энэ дээр юу байна вэ гэхээр санхүүгийн тайлан, төсөв болон бусад зүйлтэй холбоотойгоор ер нь хуулийн хугацааг тогтоохдоо 01 сарын 01 юм уу, 4 сарын 01 юм уу, 7 сарын 01 юм уу. Ингэж тавьдаг.

Тийм учраас энэ 12 сарын 31 гэхээр жишээ нь 12 сарын 31-ний өдөр байлаа гэхэд хэрэгжлээ гэхэд 01 сарын 01 гэхээр нэг өдрийн санхүүгийн тайлан гаргаж өгөх шаардлагатай болчихоод байгаа байхгүй юу даа. Энэ 31 гэж бичигдэхээр.

Тийм учраас Их Хурлын даргыг энэ 2026 оны 01 сарын 01 буюу одоо нэгхэн өдрийн дараа гэсэн үг. 2025 оны 12 сарын 31 биш, 2026 оны 01 сарын 01-нээс хэрэгжих гэж гүйцээн боловсруулах чиглэл өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Санал гаргасан гишүүдийг төлөөлж Аюушийн Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан Улс төрийн намын тухай хуулийг маш удаан хугацаанд маш олон эрдэмтэн судлаачид, улс төрийн намуудыг оролцуулж 18 жилийн дараа Улс төрийн намын тухай хуулийг баталсан.

Энэ хуультай холбоотойгоор Дээд шүүхэд дүрэм, хөтөлбөр, бүтцийнхээ өөрчлөлтийн талаар бүртгүүлэх хугацаа, энэ жил Улсын Их Хурлын сонгууль, орон нутгийн сонгууль болсонтой холбоотой хийгдэж чадаагүй зарим намууд үлдсэн гэдгийг ойлгож байгаа.

Ийм ч учраас Засгийн газраас бусад улс төрийн намаас өгсөн саналын дагуу хуулийн хэрэгжилтийг хойшлуулах санал оруулж ирсэн.

2027 оны 8 сарын 01 хүртэл гэж оруулж ирсэн.

Ингэхдээ бидний хувьд яах вэ сонгуультай холбоотойгоор хойшлуулах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг ойлгож байна.

Ийм ч учраас энэхүү хуулийг хэлэлцэх эсэхийг оруулж ирэхэд дэмжээд явсан юм. Гагцхүү 3 жилээр хойшлуулна гэдэг нь өөрөө буруу юм. Үүн дээр Сонгуулийн ерөнхий хороо хүртэл хамгийн цаад тал нь 2025 оны 8 сарын 01 гэж өөрчлөх ёстой гэдэг ийм албан ёсны байр суурийг хүртэл илэрхийлж байсан.

Ийм ч учраас өнөөдөр 37 улс төрийн нам өнөөдөр иргэдтэйгээ ойрхон байж, намынхаа гишүүдээ сонсож, их хурлаа хийдэг байж, энэ Монгол Улсад ардчиллийг бэхжүүлэх тал дээр өөрсдөө улс төрийн намууд цэгцрэх ёстой юм гэдэг үүднээс нэг жилийн хугацаа байх нь зөв юм гэж энэхүү ажлын хэсгийн санал дээр энд байгаа 20 Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдээр нэмэгдэж, Г.Уянгахишиг ажлын

хэсгийн гишүүн гэдгээрээ 21 эмэгтэй гишүүн гарын үсэг зурж энэхүү саналыг гаргасан юм.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор гэж байгаа юм. Б.Пүрэвдорж дарга аа, 31-ний дотор.

Тэгэхээр тэр нь өмнө нь ч байж болно. Таны хэлж байгаа шиг нэг хоногийн зөрүү гарахгүй. 2025 он дотроо багтаагаач ээ. Хэрэвзээ 31 буруу байгаа бол Д.Амарбаясгалан дарга аа, болохгүй бол 2025 оны 8 сарын 01 гэдэг анхны саналаар нь явах явахыг бид одоо бас өөрчлөн найруулж өгч болно гэдэг саналаа хэлэх гээд байна.

Нэг сануулах юм нь Улс төрийн намын тухай хуулийн энэхүү орж ирж байгаа асуудлыг дэмжихгүй байна гээд энэ зарчмын зөрүүтэй саналыг эсэргүүцэж татгалзсан санал өгөх юм бол Засгийн газраас орж ирсэн анхны төслөөрөө буюу 2027 оны 8 сарын 01 хүртэл болж өөрчлөгдөнө.

Ийм учраас эрхэм гишүүд ээ, эмэгтэй гишүүдийгээ болон ажлын хэсгийн саналыг хүндэтгэж энэхүү зарчмын зөрүүтэй саналыг зөвшөөрч саналаа өгөөч ээ гэж хичээнгүйлэн хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд санал илэрхийлсэн. Санаачилж өргөн барьсан гишүүд бас өөрсдийн байр суурийг илэрхийлж байна.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хороонд гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Г.Уянгахишиг гишүүн. Төрийн байгуулалтын байнгын хороо юм уу?  
Г.Уянгахишиг гишүүн.

**Г.Уянгахишиг:** Энэ дээр Б.Пүрэвдорж гишүүний хэлээд байгаа. Байнгын хороон дээр бас гаргасан юм.

Тэгээд Байнгын хороон дээр бас тайлбар өгсөн юм. Яагаад ажлын хэсэг өөрөө 2026 оны 01 сарын 01 гээгүй вэ гэхээр нэгдүгээрт 2026 оны 01 сарын 01 чинь өөрөө амралтын өдөр байгаа.

Тэгээд дээрээс нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн дотор буюу 31 өөрөө дотор нь орж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ нь өөрөө зарчмын хувьд ямар ч ялгаа байхгүй. Тэртээ тэргүй 01 сарын 01 амралтын өдөр учраас 12 сарын 31-ний дотроо л бүртгэлээ хийлгэх ёстой байхгүй юу.

Тийм учраас энэ дээр энэ горимын саналыг дэмжих шаардлага байхгүй гэж үзэж байгаа юм.



Нэгэнт ажлын хэсэг өчнөөн хуралдчихлаа, Байнгын хороо хуралдчихлаа, хэдүүлээ санал, дүгнэлт өчнөөн саналаа ярилцчихлаа. Энэ дээр зарчмын хувьд ямар ч ялгаагүй юман дээр гүйцээн боловсруулах аваад байх шаардлага байхгүй гэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Санал сонслоо. Санал хураалт. /алх цохив/

Би саналаа өгч чадсангүй шүү. 100 гишүүн санал хураалтад оролцсоноос 65 гишүүн дэмжигдлээ.

Намайг дэмжсэнд протоколд авахыг хүсье. Б.Бейсен гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Б.Хэрлэн гишүүн, М.Энхцэцэг гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн, Р.Батболд гишүүн, Г.Ганбаатар гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн нар дэмжсэнээр протоколд бүртгүүлж байна. З.Мэндсайхан гишүүн бас дэмжсэнээр протоколд бүртгүүлж байна.

Олон гишүүн учраас би бас төлөөлөөд микрофонд хэлчихлээ шүү. Дараагийн санал хураалт.

Төслийн 2 дугаар зүйлийн “батлагдсан өдрөөс” гэснийг “2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61 гишүүн дэмжсэн байна. Гишүүдийн олонх дэмжлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

---

**Хоёр. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”  
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

---

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нам, эвслийн бүлгээс ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын орол хорооны бүрэлдэхүүний талаарх

---

саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшинийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Дуламын Бум-Очирыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очирыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Дашцэрэнгийн Энхтүвшинийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоол баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

76 гишүүн дэмжиж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал дэвшүүлъя.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд оръё.

---

**Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай**  
**хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд**  
/Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/

---

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

---

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Индэрт урьж байна.

**Б.Жавхлан:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай, оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олон нийтийн болон хараат бус хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга бат, хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулах үйлдвэрүүдийг татварын бодлогоор дэмжих зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх төслийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

4.Төсвийн урсгал зардал бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийн дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

5.Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

6.Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, байгаль, цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлийг хамгаалах зорилгоор “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Хууль тогтоомжийн төслүүд батлагдсанаар бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх, татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх урсгалыг бууруулах боломжийг бүрдүүлнэ.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.

Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг уншиж танилцуулна.

Индэрт урьж байна.

**П.Ганзориг:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 11 хууль, Монгол Улсын Их Хурлын 4 тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа шийдвэрлэсэн бөгөөд Төсвийн байнгын хороо 2024 оны 12 сарын 06-ны өдрийн хуралдаанаар уг хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагчаас эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгож, төсөв хооронд үе шаттай оновчтой зохицуулалтын импортыг орлох, экспортыг дэмжсэн татварын бодлогыг хэрэгжүүлэх, төсвийг алдагдалгүй байлгах зарчимд нийцүүлэн хэрэгжиж эхлээгүй байгаа зарим төсөл, арга хэмжээг зогсох, мөн Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эргэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээлд үнэт цаасны арилжааг эхлүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, нийслэл Улаанбаатар хотын

төвлөрлийг сааруулж, бүс нутгийн хөгжлийг дэмжих, ургамал хамгааллын тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт оруулах, урсгал зардлыг бууруулж байгаатай холбогдуулан төсөвт хэмнэлт, арга хэмжээ авах зэрэг зорилгын хүрээнд холбогдох хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлсэн бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нийт 11 хууль, 4 тогтоолын төслүүд буюу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хуулийн зарим зүйл, даалт заалт хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих сан тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Засгийн газар үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Баярсайханы Солонго Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Доржсүрэнхорлоогийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн

Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэхээр байгаа.

Байнгын хорооны хурал өргөн болж олон гишүүд асуулт асууж, үг хэлсэн байгаа. 2 гишүүн асуулт асуух юм байна.

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя.

**Г.Уянгахишиг:** Би товчхон асууя. Одоо өнөөдөр дагалдах хуулиудыг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байгаа учраас нэг л хууль дээр хэлэлцэхгүй байгаач ээ, хэлэлцэхээс татгалзаач ээ гэдэг энэ саналыг гишүүддээ хэлмээр байгаа.

Энэ нь болохоор Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гээд хууль оруулаад ирсэн байна.

Энэ нь өөрөө тухайн Кино урлагийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр бүлгийг бүхэлд нь хүчингүй болгох буюу энэ 4 дүгээр бүлэг өөрөө энэ кино урлагийн салбарын бүр бодлоготой холбоотой маш том зохицуулалтууд байгаа. Энэ зөвхөн дэмжих сантай холбоотой биш байхгүй юу.

Тэгэхээр дэмжих сангийн. Одоо жишээлбэл би энэ төсөв дээрээс хайлаа л даа. 2025 оны төсөв дотор 100 сая төгрөг л туссан байсан байна шүү дээ. Тэгээд яагаад 100 сая төгрөгөөс болоод кино урлагийн салбарын бүхэл бүтэн бодлогын нэг баганыг нь ингээд аваад хаячхаж байгаа юм бэ? Тэгээд энэ дээр үнэхээр гайхаж хүлээж авч байна.

Тэгэхээр гишүүддээ хэлэхэд энэ кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэхээс татгалзаж өгөөч ээ гэдэг хүсэлтийг илэрхийлмээр байна.

Тэгээд асуулт нь өөрөө яагаад яг энэ хуулийн энэ 4 дүгээр зүйлийг буюу Кино дэмжих сан чинь зөвхөн төсвөөс санхүүждэг биш. Төсвөөс болон хандив тусламж, дээрээс нь гадаадаас Монголд гаргаж байгаа киноны ашгаас 2 хувь нь ордог.

Дээрээс нь яг энэ дэмжих сангийн тусламжтайгаар өнөөдөр жишээлбэл “VIVANT” гээд Японы хамтарсан кино байна. “Өрнөдийг зорих зам” гээд Солонгостой хамтарсан кино байна.

Эдгээр кинонуудын зураг авалтыг Монголд хийсэнтэй холбоотойгоор 10 хэдэн тэрбум, бараг 20-иод тэрбум төгрөг Монголын зах зээлд ороод ирчихсэн байгаа шүү дээ.

Энэ дээр чинь өчнөөн олон хүний бас цалин хөлс яригдсан байгаа.

Гэтэл энэ бүх юмыг байхгүй болгох гээд байгааг. Хэрвээ үүнийг хэлэлцүүлэх юм бол битгий төсөв дагаж оруулж ирээч ээ. Тусад нь хэлэлцүүлээч. Энэ дээр судалгааг нь, тэр киноныхны өөрсдийнх нь дуу хоолойг сонсмоор байна.

Энэ дэмжих сангийн зарцуулалтыг нь сонсмоор байна.

Өнөөдөр бид том том 3 Таллиных, Канных, ингээд том кино наадмуудад манай кинонууд уралдаад өрсөлдөөд шагналуудаа авч байна шүү дээ. Энэ чинь өөрөө энэ 2022 оноос үйлчилж эхэлсэн хуулийн өөрийнх нь эерэг үр дагаврууд.

Тэгэхээр энэ болгоныг зүгээр ингээд төсвийн хууль дагуулж байна гээд ямар ч судалгаагүйгээр, ямар ч салбарынхны үг хэл байхгүйгээр ингээд оруулаад ирж байгааг эсэргүүцэж байна.

Тийм учраас энэ хуулийг хэлэлцэхээс татгалзаж өгөөч ээ гэдэг хүсэлтэй байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье. Ажлын хэсэг хэн хариулах вэ? М.Санжаадорж дарга хариулъя. 2 дугаар индэр.

**М.Санжаадорж:** Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Кино урлагийг дэмжих санг энэ Төсвийн тухай хуультай хамт татан буулгахаар оруулж ирсэн байгаа.

Үндсэн үндэслэл маань юу байсан бэ гэхээр уг сангийн хөрөнгийг зарцуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч буюу соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрийнх нь яамны бүтцэд аваад явах боломжтой байна гэж үзсэн байгаа.

4 дүгээр бүлэг дээр ямар асуудлыг зохицуулсан бэ гэхээр кино урлагийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудал байгаа. Энэ бол сангийн хөрөнгөөс зарцуулах зардлууд байгаа.

Түрүүн гадаад улсын нэртэй компаниуд, кино үйлдвэрлэгч нар Монголд хэрвээ кино зураг авалт хийх юм бол бид татварын буцаалт өгч байгаа. Гарсан нийт зардлын 30 хувийг өгөх асуудал 5 дугаар бүлэг дээр байгаа. Тэр бүлэг хэвээрээ үлдэж байгаа.

Кино урлагийг дэмжих сан өөрөө нийтдээ 10 тэрбум төгрөгийн зарлага гаргасан байгаа.

Энэ зарлагынхаа үр дүнг бид эргээд хянах зорилгоор Кино урлагийн зөвлөл нь хэвээрээ хадгалагдана. Энэ зөвлөл гаргасан санхүүжилтийн эргэн төлөлтийг хариуцахаар холбогдох зүйл, заалтыг оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Ж.Ганбаатар:** Юуны өмнө Ардчилсан намынхаа нөхдөдөө баярын мэнд хүргэе. /алга ташив/ Баярлалаа.

Сая Байнгын хороон дээр 2 сайд байгаагүй учраас би асуултаа. Уг нь чуулган дээр асууя гэж бодоогүй. Хоёр асуулт асуугаадахъя.

Энэ Төр, хувийн хэвшлийн тухай хуулийг 2022 онд баталсан юм. Л.Гантөмөр сайд аа.

Тэгээд энэ Төр, хувийн хэвшлийн тухай хууль. Таны ер нь өчигдрийн гишүүдийн асуултад хариулж байгаа хариултыг сонсохоор энэ бол төр хувийн хэвшлийн хүрээнд их олон ажил хийгдэх нь ээ гэдгийг би ойлгож байгаа юм. Тийм ээ. Төсвөөс хийгдэж байгаа ажлууд, гадаадын тус зээл тусламж гэдэг юм уу.

Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн хуулийг өөрчилчхөж болоогүй юм уу? Сая.

Би Ерөнхий сайдтай гурав, дөрвөн удаа хувийн хэвшлийнхэнтэй уулзалтад оролцсон. 2023 онд, 2024 онд.

Тэгээд энэ Төр хувийн хэвшлийн хууль болохгүй байна гэдгийг хувийн хэвшлийнхэн маш их ярьж байгаа байхгүй юу.

Тэгээд өнөөдрийг хүртэл энэ 2022 оны чинь баталсан хуулиар явж байгаа ажил, үйлчилгээ алга байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг сая энэ өргөн барихдаа хуулийг нь өөрчлөх. Би зүгээр нэг хуудас л зүйл харсан. Төр, хувийн хэвшлийн талаар нэг хуудас. Зүгээр нэг жоохон магтчихсан маягтай юм бичсэн байна лээ.

Би ажлын хэсэгт нь ороод уг нь тухайн үед ажлын хэсэгт нь зөндөө зүйл ярьсан юм. Тэгээд тухайн үед тэгээд бараг загнуулаад л үлдсэн юм. Та буруу бодож байна. Энэ хууль сайхан хуулиа. Харж байгаарай. Маргааш гоё болчихно гэсэн. 2022 он дууслаа. 2023 он дууслаа. 2024 он дууслаа. Одоо 2025 он эхэлж байна.



Тэгээд үүнийгээ уг нь өөрчилчихсэн бол таны ярьж байгаа одоо тэр хувийн хэвшлээр ажлуудаа хийлгүүлнэ, төр ер нь томоохон бүтээн байгуулалтаа дэмжинэ. Маш зөв ярьж байгаа. Тэр чинь явах ёстой байхгүй юу.

Тэгээд хууль чинь одоо ийм. Тэгээд засаг эсвэл нэг журам батлах юм уу энэ тэр гээд. Тиймэрхүү байдлаар энэ явахгүй л дээ.

Уг нь үүнийг засаад явчихвал. Би бол тэр том том төсөл, хөтөлбөр, тэр төмөр замын холболт 100 хувь гараа өргөөд дэмжиж байгаа. Та өөрөө үүнийг мэдэж байгаа.

Үүнийг яагаад засчхаж болоогүй юм бэ? Сая би Байнгын хороон дээр асуух гэсэн. Та байгаагүй л дээ. Хэрвээ байсан бол би ахиад нэг ажил удаад энд асуугаад байх шаардлага байхгүй байх.

Энэ АМНАТ-ын татвар гэдэг чинь гишүүд сайн мэдэж байх ёстой.

“Зарцуулдаг татвар” биш шүү дээ. [АМНАТ-ын татвар гэдэг чинь](#) **“хадгалдаг”**, **“үржүүлдэг”** [татвар, мөнгө](#).

Тэгээд үүнийг ярьсаар байгаад нь “Ирээдүйн өв сан”-д **65.0 хувийг хадгална** гэсэн юм. Тэгээд Их Хурлын гишүүд үүнийг ёстой маш олон талаас нь ярьж байгаад дэмжсэн юм.

Тэгсэн **өнөөдөр 40 хувь**. Тэгээд яг ирээдүйд хадгалах уу, үгүй юу? Уг нь энэ АМНАТ-ын татвар гэдэг чинь

- ▶ *НӨАТ-ын татвар биш,*
- ▶ *Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар биш,*
- ▶ *Нийгмийн даатгалын шимтгэл биш.*

Энэ АМНАТ-ын татвар гэдэг чинь уг нь шал өөр, утга нь өөр. Л.Гантөмөр сайд сайн мэдэж байгаа.

Тэгэхээр үүнийг бид ингээд л өчнөөн олон зүйл ярьж өмнөх Их Хурал баталчихсан 65 гэсэн зүйлийг өнөөдөр тэгээд л 40.

Засгийн газар 40 гэж оруулж ирсэн юм. Өмнөх жил.

Тэгээд Их Хурлын гишүүд олон талаас нь ярьсаар байгаад 65 болгосон юм. Тэгсэн та нар буруу ярьж байна. Ж.Ганбат хариулж байна лээ л дээ. Та нар сонин шийдчихсэн шүү дээ. Бид буцаагаад 40 болгосон.

Тэгээд Их Хурлын шийдвэрийг бол нээрээ. Чи нэг ярьж л байдаг юм шүү дээ. Уучлаарай. Тэгээд буцаагаад л 40.

Энэ ч одоо яах вэ ингээд. Уг нь төсөл, хөтөлбөр маш сайн явах ёстой. Тэр биржээр зарж байгаа нүүрсний хэмжээ үнэхээр 60, 70 хувь буусан. Тэр хэвлэл мэдээллээр ярьж байгаа хүмүүс нь жилийнхээ дүнг нэг тоймтой юм яриад л явж байгаа шүү дээ. Тэгээд явж л байгаа шүү дээ. 50 хувьтай.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Тийм. Олонбаяр давхцаж байгаа юм байна шүү. Тийм. Ардчилсан намынхаа Их Хурлын гишүүддээ намын хамт олонд нь баярын мэнд хүргэе. Нэгт.

Хоёрт, өнөөдөр энэ долоо хоногт Монгол Улсын эдийн засаг, санхүүчдийн баярын долоо хоног болж байгаа юм. Тийм.

Тэгээд Монгол Улсын хөгжлийн төлөөх энэ хүнд албанд, мөн энэ төсвийг боловсруулах гэж сүүлийн 3, бараг 4 дэх сар луугаа орж байна. Өдөр шөнөгүй ажиллаж байгаа энэ салбарын нийт хамт олон, яамныхаа хамт олон, энэ удаагийн төсөв дээр өндөр ач холбогдол өгч ингэж анхаарал тавьж хичээнгүйлэн ажиллаж байгаа Улсын Их Хурлын гишүүддээ нийт санхүүжлийнхээ өмнөөс талархал илэрхийлж, нийт санхүүчид маань энэ долоо хоногт, маргааш, нөгөөдөр баярууд нь тэмдэглэх юм байгаа юм. Тэгээд сайхан баярлацгаараарай.

Нөр их хөдөлмөр дундуур хичээж ажиллацгааж байгаа. Манайхан маш өндөр ачаалалтай ажиллаж байгаа. Дахин дахин баярын мэнд хүргэе. /алга ташив/

Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Амьдрал дээр хуулиуд их шалгагддаг. Болдог ч юм байна, болохгүй ч юм байна. Тэгээд сайжруулах зүйлүүд дээр хэдүүлээ хамтраад ажиллацгаая. Яг үнэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль том агуулгаар нь харах юм бол өмнө нь нөгөө Концессын хууль байхад аягүй их хашраачихсан байхгүй юу. Концессын хууль маш их хашраасан. Ялангуяа төсвийг даанч яв даа гэмээр хашраасан.

Тийм учраас ер нь нэлээн тийм эрсдэлүүдийг нь хааж тооцож бодож ингэж хийгдсэн хууль байгаа юм. Энэ нь эргээд үүнийгээ идэвхжүүлж өгөх биш хаачхаад байгаа бол үүнийгээ суллаад өшөө илүү их либералчлаад явж болно л доо. Энэ дээрээ тэгээд хамтраад ажиллацгаая.

Уг нь темплэйт нь яг Нэгдсэн Үндэстний Байгууллагын загвар хууль дээр хийсэн. Яг олон улс, гадна талдаа их үлгэр ч хууль болсон байгаа юм. Тэгээд энэ дээрээ бүгдээрээ ажиллацгаая ажиллацгаая.

Хоёрдугаарт, АМНАТ дээр тэр 40 бол Ж.Ганбаатар гишүүн ээ, та Засагт байхдаа хэдүүлээ сууж байгаад л үүнийг 40 болгосон шүү дээ.

Анх бүр тэглээд. Нөгөө ковидын үеэр тэглэж байгаад энэ мөнгөөр хүүхдийн мөнгө тавьсан юм. Тэгээд бас тэр чинь төсөв дараахан жил нь тийм хурдан амар болчихоогүй. Ингээд 20, 40, 65 гээд шат шатаар нь буцаагаад тавьж байгаа юм.

Тэгэхээр өмнөх жил 20 байсан. Одоо ирэх жил 40. Тэгээд түүний дараа жил төсөв боломжтой үүнийг даахаар болоод ирэхээр буцаагаад 65-даа хүрнэ. Ийм л шат дараатай буцаагаад тавьж байгаа зүйл.

Түүнээс биш 65-ыг 40 болгочихсон зүйл биш.

Хүүхдийн мөнгө тавих гээд тэгсэн байсан. Үүнийгээ шат дараатай буцаад тавьж байна л гэж.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ж.Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Л.Гантөмөр сайд тэгж байгаад дараа нь надад нэг тодорхой хариулт өгчихнө биз дээ.

Ер нь Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яамыг сайн шахах хэрэгтэй шүү.

Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яамтай нэг урсгалд биш, ер нь Эдийн засаг, хөгжлийн яам манлайлаад Сангийн яамыг шахах хэрэгтэй. Яг л манай Б.Жавхлан сайд ингэж л хариулна л даа.

65 биш 40. Яг бараг асуусан хүнийх нь буруу юм шиг л юм ярьж байгаа юм.

Тэгэхээрээ наадах чинь 40 байсныг 65 болгочоод байгаа байхгүй юу. 65 байсныг 40. 65-аа ирээдүй рүү хадгалах ёстой. Тэгээд мань хүний хариулт ер нь ийм л дээ.

Тэгэхдээ ер нь Эдийн засаг, хөгжлийн яам манлайлаад Сангийн яамыг шахаад ер нь бараг тийм л байх ёстой. Тэгж л бид Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулсан. Тэгэхгүй бол нэг урсгалд явж байна гэвэл энэ өөрөө сайжрахгүй шүү гэдгийг сануулж хэлье. Баярлалаа. Дууслаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Б.Жавхлан сайд аа, өчигдөр төсөв хэлэлцэж байхад гишүүдээс Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хэрэгжилт хувийн хэвшлээр бас зарим төсөл, хөтөлбөрүүдийг гүйцэтгүүлэх боломж гэдэг зүйл хөндөгдөөд байгаа юм.

Та бүхний хариулт болохоор өмнө нь концесс гэж гарч ирээд алдчихсан учраас хэрэгжүүлж болохгүй байна гэдэг хариулт яваад байдаг.

Тэгэхээр нэг зүйлийг хэдүүлээ бодох ёстой. Тэр үед гаргасан улс төрчдийн алдааг өнөөдөр нийгэм, эдийн засгаараа, бизнес эрхлэгч дээрээ хамтдаа үүрээд байж бас болохгүй. Алдаа гарсан байж болно. Одоо засах ёстой.

Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг өөрсдийн хөрөнгө мөнгө, хүчээрээ хийж гүйцэтгэх тэр боломжийг магадгүй Улсын Их Хурлаар оруулж ирж нээлттэй хэлэлцэж, ил тод байдлыг нь хангаад боломж олгоод явах нь улс орны хөгжилд онцгой хувь нэмэр үзүүлж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тэгэхээр энэ чиглэл дээр Засгийн газар Л.Гантөмөр дарга, манай Сангийн сайд Б.Жавхлан нар энэ дээр санаачилгатай ажиллахыг та бүхнээс хүсэж байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан дэмжсэн болон эсрэг байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Алга байна. /алх цохив/

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

72.8 хувиар санал.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

68.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

72.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.8 хувиар санал дэмжигдлээ.

5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.8 хувиар санал дэмжигдлээ. Д.Батлут гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

6.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

37.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

39.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

9 дэмжигдсэнгүй. 45.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гишүүд ээ, чимээгүй энэ яасан их дуу чимээтэй болчхов оо.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явагдсан.

45.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дэмжмээр байгаа бол Та бүхэн өөрсдөө анхааралтай бай. Тэгээд дахин дахин санал хураалгаад.

Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир гишүүн горимын санал.

**Т.Аубакир:** Тийм. Сая дэмжиж санал өгсөн боловч би хуруу болохгүй байна.

Тийм учраас саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хураалгаж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Тилеуханы Аубакир гишүүний горимын саналаар саяын 9 дэх саналыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.2 хувиар горимын санал дэмжигдлээ.

9 дэх саналыг ахиж санал хураалт явуулъя.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувиар санал дэмжигдлээ.

10. Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд гишүүд анхааралтай. Г.Уянгахишиг гишүүн ээ, танхимд яагаад орилоод байна аа. Гишүүд анхааралтай 5, 6-хан санал дээр төвлөрөөд саналаа өгчхөөч. Тэгээд эргэж буцаад хэдүүлээ ийм байдлаар асуудал шийдэгдэхгүй шүү.

10 дахь санал хураалт.

46.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

11. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

69.9 хувиар санал дэмжигдлээ.

12. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

70.9 хувиар санал дэмжигдлээ.

13.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

77.7 хувиар санал дэмжигдлээ.

14.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал.

72.8 хувиар санал дэмжигдлээ.

15.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Дэгийн тухай хуулийн 36.14-д санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно.

Хэд хэддүгээр санал хураалт буцаж байгаа билээ. Ц.Даваасүрэн гишүүн горимын санал.

**Ц.Даваасүрэн:** Би нэг зүйлийг бас та нарт анхааруулъя гишүүд ээ.

Тэгээд тэр ваучерын асуудлыг өмнө нь ажлын хэсгээс бас одоо ингээд хасъя гээд оруулсан. Чуулган дээр бас босгоцгоосон. Дараа нь одоо тэгээд Байнгын хороо, ажлын хэсэг муу байна гээд л ингэцгээсэн шүү.

Тэгээд одоо ахиад үүнийгээ хамгаалж байгаа бол Байнгын хороо, ажлын хэсэг ямар ч буруу байхгүй шүү. Би албан ёсоор мэдэгдье.

Хэрвээ энэ асуудлаа дахиж шийдье гэж байгаа бол горимын санал гаргаад шийд ээ.

Түүнээс биш одоо ингээд хамт олноороо, олонхоороо шийдвэр гаргачхаад, тэгээд ганц хоёр хүн рүү чихээд сууж байж болохгүй шүү дээ. Үүний өмнөх дээр хасъя гэж чадаагүй. Ж.Баярмаа бүр Байнгын хороон дээр орж ирээд чадаагүй. Ажлын хэсэг мөн саналаа оруулаад бас чадаагүй.

Тэгчхээд ингээд хамгаалаад байх юм бол одоо бас болохгүй шүү.

**Д.Амарбаясгалан:** 15 дахь санал хураалтын дүн 74.8 хувиар дэмжигдсэн байгаа.

Ингээд гишүүдийн олонхын саналаар өргөн баригдсан. Санал хураагаад алх цохичихсон асуудлыг горимын саналаар дахин санал хураалгах дэг байхгүй. Би дэгийн зөрчилд орно.

Тийм учраас санал хураалгахгүй.

Ингээд орж ирсэн санал дотор 6, 8, 10 дахь тогтоол, хуулийн төслүүд дэмжигдээгүй.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Хуулийн төсөл буцаах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсон тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийн асуудалд орно. Гишүүд ээ, асуудал байгаа шүү.

---

### **Дөрөв. Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно**

---

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу эцсийн найруулгыг Байнгын хороо бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

---



2.Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцъё. /алх цохив/

3.Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцъё. /алх цохив/

Өнөөдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул.

Хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг зөвхөн Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Ингээд өнөөдрийн чуулган хаасныг мэдэгдье. /алх цохив/

**Хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 12 цаг 06 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**